



“ИРГЭНИЙ БОЛОВСРОЛООР ДАМЖУУЛАН ЗАЛУУЧУУДЫГ  
ЧАДАВХЖУУЛАХ НЬ” ТӨСӨЛ

**ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН  
ИРГЭНИЙ БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН  
ХӨТӨЛБӨР, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ**

СУДАЛГААНЫ ТАЙЛАН



УЛААНБААТАР, 2012

**АГУУЛГА:**

**УДИРТГАЛ**

**НЭГ: ИРГЭНИЙ БОЛОВСРОЛ СУРГАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ:  
ОРОЛЦОГЧДЫН ҮНЭЛГЭЭ**

**ХОЁР: “ИРГЭНИЙ БОЛОВСРОЛ”-ЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР**

**ГУРАВ. СУРАХ БИЧИГ, СУРГАЛТЫН ХЭРЭГЛЭГДЭХҮҮНИЙ ТУХАЙД**

**ДӨРӨВ. БАГШ, БАГШ НАРЫН МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭЛТ**

**ТАВ. ИРГЭНИЙ БОЛОВСРОЛ БА ИРГЭНИЙ НИЙГМИЙН  
БАЙГУУЛЛАГА**

**ДҮГНЭЛТ, САНАЛ**

**АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ**

- Баримт бичгүүд
- Асуулгын судалгааны мэдээлэл
- Ярилцлагын судалгааны тэмдэглэл

## УДИРТГАЛ

**Судалгааны зорилго:**

Судалгааны зорилго нь Ерөнхий боловсролын сургуулийн (ЕБС) иргэний боловсролын сургалтын хөтөлбөрийн агуулга, сургалтын гарын авлага, хэрэглэгдэхүүнийг шинэчлэн сайжруулахад чиглэгдсэн санал, зөвлөмж боловсруулахад оршино.

**Судалгааны зорилт:**

- Иргэний боловсролын сургалтын оролцогч талууд болох багш, сурагч, багш бэлтгэх сургуулийн оюутнуудаас мэдээлэл цуглуулсаны үндсэн дээр ЕБС-д хэрэгжүүлж буй иргэний боловсролын сургалтын хөтөлбөрийн агуулгад дүн шинжилгээ хийх
- Иргэний боловсролын сургалтын агуулга, сурах бичиг, багшийн бэлтгэл, хөтөлбөрийн цагийн хуваарилалт зэрэг асуудлын хүрээнд одоогийн Иргэний боловсролын сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэнд дүн шинжилгээ хийх

**Судалгаанаас хүлээгдэж буй үр дүн:**

Иргэний боловсролын сургалтын хөтөлбөрийн агуулга, хэрэгжилтэнд хийсэн дүн шинжилгээ болон хөтөлбөрийг шинэчлэн сайжруулахад чиглэсэн санал, зөвлөмжийг багтаасан судалгааны тайлан гарсан байна.

**Судалгааны арга, хэрэглэгдэхүүн:**

Судалгааны мэдээллийг ганцаарчилсан ярилцлага, фокус бүлгийн ярилцлага, асуулгын болон баримт бичигт дүн шинжилгээ хийх судалгааны аргыг ашиглан цуглуулна. Судалгаанд дараах хэрэглэгдэхүүнийг ашиглана. Үүнд:

- Багш, сурагчид, оюутнуудаас нээлттэй болон хаалттай асуултын хүрээнд хариулт авах зорилго бүхий 3 төрлийн асуулга
- Ганцаарчилсан болон фокус бүлгийн ярилцлагыг чиглүүлэх асуултууд болон ярилцлагыг чиглүүлэх аргачлалын талаарх мэдээлэл бүхий удирдамж

**Судалгааны үйл ажиллагааг явуулах ажлын төлөвлөгөө:**

№	Үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах хүмүүс
1.	Судалгааны арга зүй, хэрэглэгдэхүүн боловсруулах	2012.09.01-15	Ариунжаргал У.Туяа Ч.Алтангэрэл
2.	Судалгааны арга зүй болон хэрэглэгдэхүүний дагуу удирдамж боловсруулах		
3.	Судалгааны мэдээлэл цуглуулах	2012.09.17- 10 .2	Ариунжаргал Б. Бат-Эрдэнэ Энхтүшиг

4.	Судалгааны мэдээлэл оруулах	2012.10.01-10.10	Ариунжаргал Б. Бат-Эрдэнэ
5.	Судалгааны мэдээллийг боловсруулах, дүн шинжилгээ хийх	2012.10.10-20	У.Туяа Ч.Алтангэрэл
6.	Судалгааны үр дүнг хэлэлцүүлэх анхны уулзалтыг зохион байгуулах	2012.10.20-10.25	Р.Нарангэрэл Б. Ариунцэцэг Б. Ариунжаргал
7.	Судалгааны үр дүнг хэлэлцүүлэх 2 дахь уулзалтыг зохион байгуулах		
8.	Судалгааны тайлан бичих	2012.10.25-11.05	У.Туяа Ч.Алтангэрэл У.Туяа Ч.Алтангэрэл
9.	Судалгааны тайланг эцсийн байдлаар нэгтгэж дуусгах		

#### Судалгааны үндэслэл:

Монгол Улсын Үндсэн хуульд “хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм байгуулах” тухай заасан нь иргэнийг төлөвшүүлэх, хүүхэд залуучуудыг хүмүүжүүлэх талаар төр, боловсролын байгууллагууд, иргэдийн хувьд баримтлах гол чиглэл болсон гэж манай судлаачид үзэж байна. Энэ чиглэлийн ажлууд шууд болон дам замаар буюу төрөөс боловсролын талаар баримтлах бодлого, боловсролын салбар дахь шинэчлэлтүүд, олон улсын үндэсний төсөл хөтөлбөрүүд зэргийн хүрээнд 1990-д оноос хойш тасралтгүй явагдаж иржээ.

“Иргэний боловсрол” хичээл нь анх энэхүү нэрээр 2005-2006 оны хичээлийн жилээс эхлэн сургалтын төлөвлөгөөнд туссан байна. Тухайн үеийн БСШУЯ-наас гаргасан баримт бичигт “сонгох цаг буюу хичээлээс гадуур суралцах цагт иргэний боловсрол орно” гэж заасан бөгөөд боловсролын мэргэжлийн байгууллагуудаас тухайн хичээлийн агуулга, арга зүйг багтаасан сургалтын хөтөлбөр, зөвлөмж боловсруулагдах шатандаа явж байна. Иймд Монгол улс дахь иргэний боловсролын өнөөгийн төлөв байдлыг судалж тодорхойлох, үнэлгээ өгөхийн зэрэгцээ дэлхий дахины чиг хандлагыг судлах өөрийн орны чиг хандлагатай харьцуулан дүгнэлт хийх, иргэний боловсролын цогц хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх нь нийгмийн тулгамдсан асуудлын нэг болон тавигдаж байна.

Иргэний боловсрол, түүнийг түгээн дэлгэрүүлэх сургалт, боловсрол нь манай улсын хүүхэд залуучуудын төлөвшил, хөгжилд чухал үүрэг гүйцэтгэнэ гэдэгтэй боловсролын харилцаанд оролцогчид санал нийлж байгаа бөгөөд харин түүнийг бодлогын болон судалгааны үндэслэлтэй, сурган хүмүүжүүлэх ухаан, боловсрол судлалын онол арга зүйд тулгуурлан хөгжүүлэх, боловсронгуй болгох шаардлагатай байгаа чухам энэ үед иргэний боловсролын сургалтын хөтөлбөрийн агуулга, сургалтын арга зүй, хэрэглэгдэхүүний талаар тухайн харилцааны үндсэн оролцогчдоос мэдээлэл цуглуулах зорилгоор энэхүү асуулга, ярилцлагын судалгааг явуулав.

#### Судалгаанд оролцогчдын тухай мэдээлэл:

Асуулга судалгаанд Иргэний боловсрол хичээл заадаг багш ( $\Sigma=94$ ), ахлах ангийн сурагчид ( $\Sigma=377$ ), багш мэргэжлээр суралцаж буй оюутнууд ( $\Sigma=123$ ) гэсэн 3 бүлгийн нийт 594 хүнийг респондентээр оролцов. Мөн тоон судалгааг баталгаажуулах, нэмэлт мэдээлэл цуглуулах

зорилгоор сургалтын менежер, эрдэмтэн судлаачид, боловсролын газрын мэргэжилтэн, иргэний байгууллагын төлөөлөл, багш нартай ярилцлага хийсэн.


Хүснэгт 1: Тоон болон чанарын судалгааны оролцогчид

Судалгааны арга	Оролцогчид	Байршлаар				Бүгд	
		Улаанбаатар хот	Төв аймаг Эрдэнэ сум	Сэлэнгэ аймаг			Говьсүмбэр аймаг Сүмбэр сум
				Ерөө сум	Бугант баг		
Ганцаарчилсан ярилцлага	Сургалтын менежер	4	-	-	1	1	6
	БЯ,НБГ-ын мэргэжилтэн	2	-	-	-	-	2
	Эрдэмтэн, судлаачид	2	-	-	-	-	2
	ИНБ-н төлөөлөл	3	-	-	-	-	3
	Бүгд	11	-	-	1	1	13
Бүлгийн ярилцлага	Бага ангийн багш нар	26	5	5	5	2	43
	Ахлах, дунд ангийн багш нар	12	5	5	5	3	30
	Бүгд	38	10	10	10	5	73
Асуулга	Бага ангийн багш	35	7	5	5	6	58
	Ахлах, дунд ангийн багш	19	3	5	5	4	36
	9-р ангийн сурагчид	104	22	19	24	19	188
	11-р ангийн сурагчид	102	21	23	23	20	189
	4-р курсын оюутнууд	20	-	-	-	-	20
	3-р курсын оюутнууд	80	-	-	-	-	80
	2-р курсын оюутнууд	23	-	-	-	-	23
	Бүгд	383	53	52	57	49	594
<b>Нийт дүн</b>		<b>864</b>	<b>126</b>	<b>124</b>	<b>136</b>	<b>110</b>	<b>1360</b>

Асуулга судалгаанд Улаанбаатар хот, Төв, Сэлэнгэ, Говьсүмбэр аймгийн 9 болон 11 дүгээр ангид суралцагч нийт 377 сурагч оролцсон байна. Нийт оролцсон сурагчдын 54,9% нь Улаанбаатар хотод, үлдсэн 45,1% нь дээр дурдсан аймгийн төв болон сумдад амьдардаг байна. Гэвч сумын төвд суралцагчид нь аймгийн төвийнхөөс ойролцоогоор 3 дахин их байна. 9 болон 11 ангид суралцагчдын тоог адил тэнцүү авсан бөгөөд харин оролцогчдын хүйсийн хувьд 40% нь эрэгтэй, 60% нь эмэгтэй, насны хувьд 12-14 насны сурагчид 40%, 15-17 насны сурагчид 60%-ийг тус тус эзэлж байна. Энэ нь тэдгээр суралцагчдын Иргэний боловсрол

хичээлд хандах хандлагыг орон нутгийн байдал, нас, хүйс, хөгжлийн ялгаатай байдлыг төлөөлж байна гэж үзэх боломжийг бүрдүүллээ.

Асуулга судалгаанд дээр дурдсаны адил нийслэл хот, сум, орон нутгийн төлөөлөл болсон 94 багш оролцсон бөгөөд үүнээс Улаанбаатар хотоос нийт оролцогчдын 57,4% нь, үлдсэн 42,6% нь бусад аймаг, сумдаас оролцжээ. Судалгаанд оролцсон багш нарын 59% нь бага ангийн багш мэргэжилтэй бөгөөд одоогоор мэргэжлийн дагуу ажиллаж байгаа, бусад багш нарын 30,9% нь түүх, нийгмийн ухааны багш нар байх бөгөөд монгол хэл болон байгалийн ухааны багш нар тус бүр 3-4%-ийг тус тус эзэлж байгаа нийт багш нарын 51% нь дунд болон ахлах ангид Иргэний боловсрол хичээл зааж байна. Багш нарын олонх нь 1-5 дугаар анги буюу бага боловсролын түвшинд, 21% нь ахлах ангид Иргэний боловсролын хичээл орж байгаа бөгөөд харин 11% нь одоогоор уг хичээлийг заагаагүй байна. Багш нарын 40% нь 16-аас дээш жил мэргэжлийн дагуу ажилласан байна.



Судалгаанд нийт 123 оюутан оролцсоны 81% нь 3, 4 дүгээр курсийн, харин 2 дугаар курсын оюутнууд 18,7% хувьтай байна. Багш бэлтгэх сургуулийн 3 дугаар ангиас эхлэн багшлах мэргэжлийн болон сурган хүмүүжүүлэх ухаан, заах аргын хичээлүүд орж, мөн багшлах дадлага хийдэг үе тул ахлах ангид суралцаж буй оюутнуудыг голлон оролцуулсан болно. МУБИС-ийн Багшийн сургууль, Байгалийн ухааны сургууль, Түүх Нийгмийн ухааны сургууль, Математик Статистикийн сургууль, Монгол судлалын сургуульд Бага ангийн багш, Газарзүй, аялал жуулчлалын багш, Монгол-Англи хэлний багш, Философи, улс төр судлалын багш, Эдийн засаг, математикийн багш зэрэг мэргэжлээр суралцаж буй оюутнууд оролцлоо. Үүнээс Багшийн сургуульд бага ангийн мэргэжлээр суралцаж буй оюутнууд дангаараа 32,5% байсан бөгөөд бусад мэргэжлийн хувьд дунджаар 15%-ийн төлөөлөл оролцсон байна.

Судалгаанд тохиолдлын түүвэр, санамсаргүй түүврийн аргыг хэрэглэж, нийслэл хот, аймаг, сумдын сургуулиуд, төрийн болон хувийн өмчит сургуулиудыг хамруулсан, үүнээс гадна боловсролын шинэчлэлийн үйл явц нь багш бэлтгэх тогтолцоонд хэрхэн нийцэж байгааг тодруулахаар манай улсын багш бэлтгэх хамгийн том институт болох Боловсролын их сургуулийн 2-4 курсын оюутнуудыг хамруулсан. Судалгаанд хамрагдсан сургуулиуд бүгд Иргэний боловсрол хичээлийг орж байгаа бөгөөд ихэвчлэн долоо хоногт 1 цагийн агуулгын хүрээнд судалдаг байна. Үүний хамт одоогоор 2-4 дүгээр дамжаанд суралцагч оюутнуудын 95,1% нь ЕБС-д суралцах хугацаандаа Иргэний боловсрол хичээлийг судалж байсан ажээ.

Иймд Иргэний боловсрол хичээлийг судалж эхэлснээс хойш тодорхой цаг хугацаа өнгөрч, түүний чанар буюу агуулга, арга зүйн хөгжил, сургууль багш нарын бэлтгэлийн асуудлаар тодорхой дүгнэлт хийх боломж бүрджээ гэж үзэж байна. Нөгөө талаас түүврийн хэмжээ, бүтцийн хувьд ЕБС-ийн Иргэний боловсрол хичээлийн сургалтын үйл явцад оролцдог олон төрлийн бүлгийн төлөөллийг хамруулсан тул тус хичээлийн агуулга, хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж чадахуйц, судалгааны бодит байдлыг хангахуйц төлөөлөл болсон гэж үзэж байна.

### **Судалгааны мэдээлэл цуглуулалт, боловсруулалт**

Уг судалгааг ерөнхий боловсролын сургуулийн Иргэний боловсролын сургалтын хөтөлбөрийн агуулга, хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх хэрэгцээнээс үндэслэн судалгааны түүврийг сонирхлын бүлгүүдийг шалгуур болгон сонгосон болно. Тухайлбал, асуулга судалгаанд Улаанбаатар болон Төв, Сэлэнгэ, Говьсүмбэр гэсэн аймгуудын Иргэний боловсролын сургалтын оролцогч талууд болох багш, сурагч, багш бэлтгэх сургуулийн оюутнуудыг оролцуулахаар тооцож, тэдний онцлог шинжийг харгалзан судалгааны хэрэглэгдэхүүнийг боловсруулж судалгааны мэдээллийг цуглууллаа. Судалгааны мэдээлэл цуглуулах ажилд нийт 4 судлаач хамтран ажилласан болно.

Цуглуулсан мэдээллийг боловсруулах ажлын хүрээнд:

- Дөрвөн төрлийн зорилтот бүлгээс авсан асуулга судалгааны мэдээллийг SPSS 16 программд нэгтгэн мэдээллийн баазыг үүсгэж, санамсаргүй болон логикийн алдаа, зөрчлийг бүх асуулгын хуудастай тулган нягтлав.
- Шаардлагатай асуулгуудыг харьцуулах, дундаж бодох зэргээр эцсийн боловсруулалт хийлээ.

### **Судалгаагаар цуглуулсан мэдээллийн хүрээ:**

Ярилцлагын судалгаагаар дараах асуудлын хүрээнд мэдээлэл цуглууллаа. Үүнд:

*Нийтлэг асуудал:*

- ✓ Иргэний боловсролын сургалтад нөлөөлж буй эерэг, сөрөг хүчин зүйлс, тулгарч буй бэрхшээл, даван туулах арга зам
- ✓ Багш, сурагчдын зүгээс тухайн хичээлийн үр дүн, хичээлийн ач холбогдлыг үнэлж буй байдал

*Сургалтын хөтөлбөрийн агуулгын талаар*

- ✓ Иргэний боловсрол хичээл дээр судалж буй зүйлс, түүний учир холбогдол
- ✓ Одоо судалж буй агуулгад шүүмжлэлтэй хандаж буй байдал
- ✓ Ирээдүйд судлах зүйлийн талаарх санал, хүсэлт

*Сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүний талаар*

- ✓ Сурах бичгийн чанар, хүртээмж
- ✓ Сурах бичгийн агуулга, арга зүй
- ✓ Сурах бичгийг зохиох, боловсронгуй болгох талаар
- ✓ Сургалтын бусад болон нэмэлт хэрэглэгдэхүүн – унших ном, бие дааж хийх дасгалын дэвтэр, аялалын удирдамж ...

*Багш нарын мэргэжил дээшлүүлэлт*

- ✓ Иргэний боловсролын багш нарын мэргэжил дээшлүүлж буй байдал
- ✓ Багш нарын заах арга зүйг дээшлүүлэх талаарх санал, шүүмж
- ✓ Багш нарын өмнө тулгарч буй бэрхшээл

Асуулгын судалгаагаар дараах хүрээний мэдээллийг цуглуулахыг зорьсон болно. Үүнд:

*Нийтлэг асуудал:*

- ✓ Иргэний боловсролын сургалтын өнөөгийн байдал, түүнд багш, суралцагчдын зүгээс өгч буй чанарын үнэлгээ
- ✓ Сургалтын чанарт нөлөөлж буй эерэг, сөрөг хүчин зүйлс, тулгарч буй бэрхшээл
- ✓ Багш, сурагчдын зүгээс тухайн хичээлийн үр дүн, ач холбогдлыг үнэлж буй байдал

*Сургалтын хөтөлбөрийн агуулгын талаар*

- ✓ Иргэний боловсрол хичээлийн агуулгын цөм, холбогдох үнэт зүйлсийн тухай төсөөлөл
- ✓ Одоо судалж буй агуулгад шүүмжлэлтэй хандах байдал
- ✓ Цаашид хичээлийн агуулгад тусгавал зохих үнэт зүйлсийн талаарх байр суурь
- ✓ Иргэний чадварыг хөгжүүлэхтэй холбоотойгоор сургуулиас санал болгож буй нэмэлт хөтөлбөр, чөлөөт цагийн үйл ажиллагааны тухай мэдээлэл

*Багш нарын мэргэжил дээшлүүлэлт*

- ✓ Иргэний боловсролын багш нарын мэргэжил дээшлүүлж буй байдал
- ✓ Багш нарын өмнө тулгарч буй бэрхшээл
- ✓ Багш бэлтгэх болон мэргэжил дээшлүүлэх сургалтын хүрээн дэх иргэн боловсролын заах арга зүй, мэргэжлийн дэмжлэг үзүүлж буй байдал

## **НЭГ: ИРГЭНИЙ БОЛОВСРОЛ СУРГАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ: ОРОЛЦОГЧДЫН ҮНЭЛГЭЭ**

Судалгаанд оролцогчид Иргэний боловсролын хичээл, түүний ач холбогдлыг эерэгээр үнэлж, түүний хөтөлбөр, агуулгыг сайн хэрэгжүүлбэл чухал холбогдолтой, үр дүнд хүргэх хичээл гэдэгт санал нэгдэж байна. Ялангуяа, багш нарын зүгээс уг хичээлийг ардчилсан иргэний үнэт зүйлс, итгэл үнэмшил, хувь хүний төлөвшил, харилцааны ур чадварыг хөгжүүлэх зэрэг олон талын ач холбогдлоор ойлгож, үнэлж байна. Эдгээрийг бүлэглэн авч үзвэл дараах 3 чиглэлд тодорхойлж болохоор байна. Үүнд:

- ✓ “Хүүхдүүдэд сайн хүн болоход нь туслана, төлөвшилд нь нөлөөлнө” гэх зэргээр хувь хүний төлөвшил, хүмүүжил талаас нь:
- ✓ “Нийгмийн харилцаанд бие даан оролцоход нь энэ хичээл тусалдаг. Оролцоотой хариуцлагатай, өөрийн гэсэн бодолтой иргэн хүнийг бэлтгэнэ. Иргэн хүн болгох зорилготой хичээл, сайн иргэн болгон төлөвшүүлэх тул хамгийн чухал хичээл” хэмээн ардчилсан нийгмийн иргэн болох талаас нь:
- ✓ “Харилцан ярилцах чадвар суулгах, ярих чадварыг нь сайжруулахад тустай хичээл” гэх мэтээр ерөнхий чадварыг хөгжүүлэхэд оруулах хувь нэмрээр нь үнэлэх зэрэг болно.

... Иргэний боловсролын хичээл зайлшгүй байх ёстой хичээлийн нэг. Өөрийн сургуулийн жишээнээс харахад энэ хичээл орсноор хүүхдүүдийн хандлага, оролцоо өөрчлөгдөж байгаа нь харагдаж байгаа. Бид чинь хүүхдүүдэд баахан шинжлэх ухаан заагаад байсан. Гэтэл одоо энэ хичээлийн хэрэгцээ байгааг мэдэрч эхэлж байгаа тухай багш нар бид нар ч хоорондоо ярилцаж байгаа...



Багш нар мөн дүгнэхдээ “энэ хичээлийг анх орохдоо л багшийн зүгээс хичээлийнхээ зорилгыг та нарт хэрэгтэй, гэдгийг нь ойлгуулчихвал хүүхдүүд их идэвхтэй сайн оролцдог, хичээлээ жүжиглэх, дүрд тоглох зэрэг аргаар явуулбал их сайн, ялангуяа хөвгүүд сайн оролцдог” гэжээ.


Мөн энэхүү хичээлийг зааж эхэлснээр ЕБС-ийн нийт сургалтад нийгмийн ухааны цаг нэмэгдэж, онолын мэдлэгийг дадлагад хэрэглэх боломж өгсөн гэдэг утгаараа нийгмийн ухааны багш нар ихээхэн дэмжиж хүлээн авсан. Нөгөө талаас, шинэ хичээл орж шинэ агуулга, хөтөлбөр тусгагдаж байгаа тул цаашид энэ чиглэлээр судалгаа шинжилгээ хийх, мэргэших зэрэг өргөн боломж багш, судлаачдын дунд гарч байгааг боловсролын арга зүйч, мэргэжилтнүүд цохон тэмдэглэсэн байна.

Багш нарын ярилцлагаас үзэхэд иргэний боловсрол хичээлийн үндсэн ач холбогдлын талаар зарчмын хувьд нийтлэг ойлголттой, түүнээс хүлээх хүлээлт мөн адил өндөр хэмжээнд байгаагийн зэрэгцээ заах арга зүй, үнэлгээ болон багшийн мэргэжил дээшлүүлэх асуудлын хувьд ч шаардлага, хэрэгцээ нь адил байна.

Энэ байдал асуулга судалгааны дүнгээр давхар батлагдсан гэж үзэх боломжтой байна. Тухайлбал, “Танай сургуульд зааж буй “Иргэний боловсрол” хичээлд чи дуртай юу?” гэсэн асуултад судалгаанд оролцогч нийт сурагчдын 338 нь буюу 90 хувь нь “Тийм” хэмээн хариулсан нь хичээлийн зорилго, түүнээс хүлээх хүлээлт хот, хөдөөгийн ялгаагүйгээр сурагчдын дунд өндөр байгааг илтгэж байна. Мөн оюутнуудын 97,6% нь “Иргэний боловсрол хичээл нь ЕБС-ийн сурагчид заавал судлах хичээлийн нэг мөн хэмээн онцолсон байна.

Иргэний боловсрол хичээлийн үндсэн зорилгыг тодорхойлох нээлттэй асуултад “Зөв боловсон иргэнийг төлөвшүүлэх” хэмээн сурагчдын 57,8% нь, “зөв харилцаа, өөрийгөө илэрхийлэх, багаар ажиллах зэрэг амьдралын ухаанд сургах” хэмээн 12,6% нь тус тус тодорхойлсон нь хамгийн олон давтамжтай хариулт болжээ. Хичээлийн үндсэн зорилгыг тодорхойлох энэхүү асуултад “Зөв иргэн болгон төлөвшүүлэх” хэмээх адил утгатай хариултыг судалгаанд оролцогч багш нарын 73,4% нь сонгож, “харилцааны чадварт суралцах, эх оронч байх, амьдралын ухаанд сургах, уламжлал, түүх зан заншлаа мэдэх” зэрэг бусад хариултуудыг тус тус 2-5% хүртэл оролцогчид тодорхойлсон байна.

График 1: Иргэний боловсрол хичээлийн гол зорилго: Багш, сурагч, оюутан




Тус хичээлийн зорилгыг тодорхойлоход оюутнуудын хувьд мөн адил байр суурьтай байна. “Зөв иргэн болгон төлөвшүүлэх, хүмүүжүүлэх” гэсэн хариултыг судалгаанд оролцогч оюутнуудын 58,4% нь өгжээ. Мөн “Иргэн хүний мэдэх ёстой мэдлэг, чадварт суралцуулах” хэмээн 11,5% нь, “нийгэмд биеэ авч явах харилцааны чадвар, дадалд сургах” гэж 8% нь сонгосон нь өмнөх сурагчдын болон багш нарын бүлгээс өгч буй хоёрдогч хариултуудтай тохирч байна. Эндээс дүгнэхэд, Иргэний боловсрол хичээлийн зорилго нь “Иргэн болон төлөвшүүлэх” үндсэн зорилготой гэдэгт манай боловсролын харилцаанд оролцогчид бүрэн санал нэгдэж байна. Нэгэнт Иргэн болох үйл явц, түүний төлөвшлийн тухай ойлголт нь өргөн хүрээний үзэл баримтлал тул эх оронч үзэлтэй болгох, ёс заншил, өв уламжлалаа мэдэх, хүндэтгэх, хамгаалах, хууль дүрэм, эрх үүргээ мэддэг хариуцлагатай иргэн болгох, нийгмийн харилцаанд зөв шударга, эрх чөлөөтэй оролцоход нь туслах, зорилго тэмүүлэлтэй, түүндээ хүрэх эрмэлзэлтэй болгох зэрэг олон тооны хариултын хувилбарууд гарч байсан нь дээрх үндсэн зорилготой харшлаагүй бөгөөд түүнийг дэмжихүйц саналууд байна гэж үзлээ.

Хичээлийн зорилгын хувьд ийнхүү нийтлэг ойлголцолд хүрч буй нь нэн чухал алхам бөгөөд харин зорилгын хэрэгжилт буюу сургалтын чанар, өгөөжийн талаарх дараагийн асуулт бидний анхаарлыг ихээхэн татсан болно. Сурагчдын хувьд сургуульдаа зааж буй Иргэний боловсролын сургалтын чанарыг 58,9% нь “Сайн”, 29,4% нь “Дунд зэрэг”, 2,9% нь “Муу” харин үлдсэн 8% нь “Мэдэхгүй” гэж хариулсан байна. “Энэ хичээл нь таныг сайн иргэн болон төлөвшихөд ямар нэгэн нөлөө үзүүлсэн үү?” хэмээн асуухад судалгаанд оролцогчдын 89,4% нь эерэг нөлөө үзүүлсэн, харин 9,8% нь нөлөө үзүүлээгүй гэж дүгнэсэн байна. Сурагчид өөрсдийг нь иргэн болон төлөвшихөд хэрэгтэй зүйлсийг заасан, нийгмийн харилцаанд оролцох, өөрийгөө илэрхийлэх, бусадтай харилцахад дэмжлэг болсон, эх орон, түүх соёлоо мэдэж түүнийг бахархах, хүндэтгэх сэдэл тэмүүлэл бий болсон, өөрийн эрх болон үүрэг хариуцлагаа мэддэг болсон зэрэг үндэслэлүүдээр уг хичээл өөрсдөд нь сайн, эерэг нөлөө үзүүлж байна хэмээн тайлбарласан байна.

Харин тухайн хичээлийн чанарын талаар бататган асуухад багш нар “Сайн” хэмээн 44%, “Дунд зэрэг” гэж 54,9% нь тус тус хариулсан байна. Үүний хамт нийт багш нарын 68% нь “Иргэний боловсрол” хичээлийг судлахтай холбоотой ямар нэгэн мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдаж байгаагүй байна. Судалгаанд оролцсон багш нарын хувьд бараг бүгдээрээ Иргэний боловсрол хичээл орсноор суралцагчид “сайн иргэн” болон төлөвшихөд эерэг нөлөө үзүүлнэ гэдэгт эргэлзэхгүй байна. Тэдний үзэж байгаагаар иргэн хүн эзэмшвэл зохих мэдлэг, чадварыг энэхүү хичээл зохих хэмжээгээр агуулсан, хичээлийн сэдэв, агуулга нь ихээхэн сонирхол татахуйц бөгөөд бага боловсролоос эхлэн үзэх болсон тул сурагчдын төлөвшилд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэнэ гэж үзэж байна. Үүний хамт тухайн хичээлийг ямар байдлаар хэрхэн заан сургах, багш нарын зүгээс хичээлийн бэлтгэлээ хэр зэрэг хангасан зэргээс шалтгаалж, суралцагчдад ямар үр дагавар болон очих нь тодорхойлогдоно гэдгийг мөн онцолсон байна.

График 2: Иргэний боловсрол хичээлийн сургалтын чанарын үнэлгээ: Багш, сурагч, оюутан



“Та тухайн үеийн Иргэний боловсрол хичээлийн чанарыг одоо хэрхэн тодорхойлох вэ?” хэмээх асуултад оюутнуудын дөнгөж 3 хувь нь сайн гэсэн бөгөөд 73,2 % нь “дунд зэрэг”, 16,3% нь “муу” хэмээн үнэлсэн байна. Энэ байдлаас харвал, тус хичээлийн сургалтын чанарын талаар оюутан, багш нарын үнэлэлт сурагчдынхтай харьцуулахад нилээд доогуур гарч байна. Энэ нь багш нар болон багш мэргэжлээр суралцаж буй оюутнуудын хувьд ЕБС-ийн сургалтын тогтолцоонд уламжлал болгон заагдаж ирсэн бусад хичээлүүдтэй харьцуулан үзсэн, нөгөө талаас иргэний боловсрол хичээлийг өмнөх жилүүдэд нэгдсэн хөтөлбөр, арга зүйн чиглэл, ном сурах бичиггүйгээр зохион байгуулж ирсэнтэй холбогдуулан хичээлийн хувьд зорилгоо хангахуйц төлөвшөөгүй хэмээн үзсэнтэй холбоотой байх талтай.

Иргэний боловсролыг ЕБС-ийн түвшинд бие даасан хичээл байдлаар үргэлжлүүлэн орох нь зүйтэй гэж багш нарын 75,8%, оюутнуудын 43,1% нь үзсэн бол бие даасан хичээл шаардлагагүй бөгөөд, бусад хичээлүүдэд нэгтгэн интеграцичлах нь зүйтэй гэж багш нарын 8,8%, оюутнуудын 22,0% нь, мөн хичээлийн дараах сургалт хүмүүжлийн үйл ажиллагааны хүрээнд олгох боломжтой гэж багш нарын 12,1%, оюутнуудын 32,5% нь тус тус хариулсан байна.

График 3: ЕБС дэх Иргэний боловсрол хичээлийн тухай оюутны байр суурь:

Иргэний боловсрол нь ЕБС-ийн бие даасан хичээл байх эсэх	Давтамж	Хувь
Тусгайлсан хичээлээр заах нь илүү үр дүнтэй	53	43.1
Бие даасан хичээл шаардлагагүй, бусад хичээлүүдэд нэгтгэн интеграцичлах нь зүйтэй	27	22.0
Хичээл бус, харин хичээлийн дараах, чөлөөт цагийн хөтөлбөрөөр хэрэгжүүлэх нь зөв	40	32.5
Бусад	3	2.4
Нийт дүн	123	100.0

Үүний хамт суралцагчдыг иргэн болон төлөвших үйл явцад бусад хичээлүүд ч мөн адил эерэг нөлөө үзүүлдэг болохыг тэдний хувьд хүлээн зөвшөөрч байна. Тухайлбал, судалгаанд оролцсон

сурагчдын 89,6 % нь судалж буй бусад хичээлүүдийг өөрсдийн төлөвшилд ямар нэгэн байдлаар тус дэм болж байгаа гэж үзжээ. Хичээл тус бүрээр ялган авч үзвэл Нийгмийн ухааны хичээл дангаар 42,2%, Түүх газар зүй 12,8%-тай удаалж, харин бусад хичээлийг нэр цохон заасан байдал 7,7%-аас 1% хүртэл буурсан харагдаж байна. Үүнээс харахад Иргэний боловсрол болон нийгмийн ухааны сургалтын чанарыг иргэн болох үйл явцтай холбогдуулан суралцагчдын зүгээс харьцангуй өндрөөр үнэлж байгааг харуулж байна. Харин бусад хичээлүүдийн хувьд хичээлийн зорилго, зорилтуудыг суралцагчдад танилцуулах, онолын мэдлэгийг хэрэглээний шинжтэй болгох, суралцагчдын цаашдын мэргэжлийн чиг баримжаа, сонирхол зэрэгтэй холбон өгөх талаар гүнзгийрүүлэн судлах шаардлагатай гэж үзэж байна.

Мөн иргэний боловсрол нь түүх, газарзүй, эдийн засаг, улс төр судлал, байгаль орчин, төрөлх ба гадаад хэл зэрэг бусад хичээлүүдтэй байнгын интеграцид байж, иргэдийг нийгмийн харилцаанд бэлтгэхэд анхаардаг байна. Эндээс гарч буй нэгэн асуудал бол иргэний боловсрол болон бусад хичээлүүдийн уялдаа холбоо, хамаарлын тухай асуудал юм. Өөрөөр хэлбэл, иргэний боловсролыг зөвхөн “Иргэний боловсрол” хичээлээр дагнан олгох, эсхүл бусад хичээлүүдэд нэгтгэн интеграцичлах боломж, бололцооны тухай цаашид дэлгэрүүлэн авч үзэх шаардлагатай байна. Энэхүү судалгааны хүрээнд уг асуудлын талаар гүнзгийрүүлэн судлаагүй боловч цаашид иргэний боловсролын талаарх үзэл баримтлалыг тодорхойлохын тулд энэ талаар нэгдсэн дүгнэлттэй болох шаардлагатай байна.

## **ХОЁР: “ИРГЭНИЙ БОЛОВСРОЛ”-ЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР**

Судалгааны ажлын үндсэн зорилтын нэг нь ЕБС-ийн тогтолцоон дахь Иргэний боловсролын агуулга, арга зүйн талаарх санал байр суурийг нэгтгэх, дүн шинжилгээ хийх явдал юм. Энэ хүрээнд бид баримт бичгийн болон ярилцлагын, асуулгын судалгаагаар цуглуулсан мэдээллийг нэгтгэн хоёрдугаар хэсэгт танилцуулж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч 2010 онд 103 тоот зарлиг гаргаж “Ерөнхий боловсролын сургуулийн хөтөлбөрт Монголын уламжлалт зан заншил, өв уламжлалд тулгуурласан иргэний боловсролын хөтөлбөрийг боловсруулж оруулах” тухай заасан байдаг. Энэ нь Монгол Улсын хүүхэд залуучууд, иргэд орчин цагийн иргэний үнэт зүйлс буюу эрхээ эдэлдэг, үүргээ биелүүлдэг, хариуцлагатай иргэн байх үнэлэмжийг төлөвшүүлэх, нөгөө талаас Монголчууд эртнээс уламжлагдаж ирсэн өв соёл, түүхтэй ард түмэн тул түүнийгээ өсвөр, хойч үедээ эзэмшүүлэх, өвлүүлэх хоёр үндсэн агуулга, зорилтод чиглэсэн байдаг. Ийм агуулга, хоорондын шүтэлцээтэйгээр Иргэний боловсролын талаарх Ерөнхийлөгчийн зарлигийн хүрээнд БШУЯ-ны зүгээс сургалтын хөтөлбөр, сурах бичиг шинэчлэх ажлыг мөн бусад хичээл сургалтын нэгэн адил хэрэгжүүлж байна. Одоогийн байдлаар 12 жилийн сургалттай ЕБС-ийн 1-5 ангийн сургалтын хөтөлбөрийг шинээр боловсруулж, түүний дагуу судлах шаардлагатай сурах бичгүүдийг зохиосон байна. Цаашдаа 6-9 дүгээр анги, улмаар 12 дугаар анги хүртэлх сургалтын хөтөлбөр, сурах бичгийг боловсруулах, эдгээр ангиудад орох багш нарыг бэлтгэх, багш нарт зориулан сургалтын CD материал, арга зүйн зөвлөмж боловсруулах зэрэг цогц зорилтыг салбарын яамнаас дэвшүүлэн ажиллаж байна. 2012-2013 оны хичээлийн жилээс БШУЯ-ны дэвшүүлж буй зорилго нь “Зөв монгол хүнийг төлөвшүүлэх” хэмээн заасан нь энэхүү ажлын нэг хэсэг нь болж байна.

Одоогийн мөрдөж буй сургалтын хөтөлбөр нь Монголчуудын үндэсний өв уламжлал, соёл ахуйд тулгуурласан уламжлалт иргэний боловсрол, нөгөө талаас орчин цагийн буюу ардчилсан


иргэн хүний үнэт зүйлс гэдэг зэрэгцээ 2 агуулгыг багтааж байна. Орчин цагийн агуулгыг ахлах ангид нь илүү хувьтай, уламжлалт иргэний боловсролын хэсгийг бага ангид нь илүү хувьтай судлахаар тогтжээ. Энэхүү агуулгын тогтолцоог урьд өмнө хийгдсэн иргэний боловсролын судалгаа болон 2010 оны Ерөнхийлөгчийн 103 тоот зарлигийн дагуу боловсруулсан гэдгийг эрдэмтэн судлаачид тэмдэглэж байна.

Иргэний боловсрол хичээлийн хөтөлбөрийн агуулга нь “Иргэний боловсролын уламжлалт зан үйл”, “Орчин цагийн иргэний боловсрол” гэсэн хоёр үндсэн айтай байна.

Хөтөлбөрийн агуулгын айнууд нь бага, суурь, бүрэн дунд боловсролын түвшинд дараах харьцаатай байна. Үүнд:

Боловсролын түвшин	Бага	Суурь	Бүрэн дунд
Иргэний боловсролын уламжлалт зан үйл	70%	50%	30%
Орчин цагийн иргэний боловсрол	30%	50%	70%

Иргэний боловсролын уламжлалт зан үйл ай нь “Зан суртахууны төлөвшил”, “Уламжлалт аж төрөх ёс”, “Үндэсний өв соёл, бахархал” гэсэн дэд хэсгүүдээс, Орчин цагийн иргэний боловсрол ай нь “Иргэний хувийн төлөвшил”, “Иргэний хариуцлага”, “Иргэн - төрийн харилцаа” гэсэн дэд хэсгүүдээс тус тус бүрдэнэ.



Ерөнхий боловсролын сургуулийн “Иргэний боловсрол” хичээлийн хөтөлбөрийн багийн тайлангаас. 2012.

Судалгаанаас үзэхэд улс орон бүрт иргэнээ хөгжүүлэх, төлөвшүүлэхэд баримтлах үзэл санаа байдаг, түүний адил монгол иргэний боловсрол нь уламжлалт үнэт зүйлс буюу бие, хэл, сэтгэл нь зөв төлөвшсөн хүүхэд, орчин цагийн буюу ардчилсан нийгмийн иргэний чадвар, үнэт зүйлсийг эзэмшсэн хүүхдийг төлөвшүүлэх үйл явц гэсэн шийдлийг хийжээ гэж ойлгож болохоор байна.

Энэхүү шийдлийг эх үндэс болгож боловсруулсан сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг цаашдаа багш нартай ярилцаж, ажиглан судалж, давуу болон сул талыг нь илрүүлэх, боловсронгуй болгох үйл явц тасралтгүй байх нь чухал юм.

Судалгаанаас үзэхэд бага ангийн сургалтын хөтөлбөр, сурах бичиг хэвлэгдэн гарсан нь багш, сурагчдад ихээхэн дэмжлэг болсон тул үүнд багш нар сэтгэл хангалуун байна гэж үзэх үндэстэй байна. Тэд бага ангид судлах агуулга тохиромжтой, ураг төрөл, монгол зан заншлаас орж байгаа нь зохистой гэж үзсэн байна. Харин дунд, ахлах ангийн хувьд нэгдсэн хөтөлбөр, агуулгын хүрээ байхгүй тул тухайн орон нутгийн БСГ болон сургуулиуд өөрсдөө

боловсруулсан сэдэв, хөтөлбөрийн дагуу сургалтыг зохион байгуулдаг байна. Тухайлбал, Нийслэлийн боловсролын газраас ЕБС-ийн түүх, нийгмийн багш нарыг хамруулсан сургалт зохион байгуулж, санал асуулга авсны үндсэн дээр нийгмийн ухааны хичээлээр үзэж байгаа онолын мэдлэгийг практикт хэрэгжүүлэх, дадлагажуулах, иргэний нийгмийн үнэт чанарыг төлөвшүүлэх үндсэн зорилгын хүрээнд Иргэний боловсрол хичээлийн зөвлөмж бүхий гарын авлага гаргасан байна. Үүнд орон нутаг судлал, орон нутгийн төр захиргааны байгууллагууд, хүний эрхийн асуудал, хүүхдийн эрх, оролцоо гэсэн 4 багц асуудлыг заахаар багш нарт зөвлөмжилсөн байна.

Сургалтын хөтөлбөрийн агуулгын талаарх багш нарын саналыг харахад нэг хэсэг нь ардчилсан нийгмийн иргэдийг бэлтгэх, тэднийг төр засагтай харилцаж, төрийн үйлчилгээг авч чаддаг болоход шаардагдах агуулгыг оруулах хэрэгтэй гэж үзэж байна. Тухайлбал, баг, хороотой яаж харьцах вэ?, хэрхэн өргөдөл гаргаж асуудлаа шийдвэрлүүлэх вэ гэх мэт асуудал сурагчдын хувьд нэн чухал, иймээс ялангуяа, дунд ангид хичээлийн хөтөлбөрийн агуулгад зан заншлаас илүүтэйгээр сайн хүн, иргэн болох талаас нь, бас хууль дүрмийг сахиж мөрдөх, хүний эрх бусдын эрх гэх мэт агуулгыг авч үзэх ёстой гэж багш нар үзсэн байна.

Иргэний боловсролын талаар их олон ойлголт байдаг л даа. Тэгэхээр нэг талыг их барихгүйгээр, жишээ нь ардчилсан нийгмийн эрх, эрх чөлөө гэх мэт сонгодог ойлголтуудыг л зөвхөн иргэний боловсрол гэнэ гэж үздэг хүмүүс бий, гэхдээ хүүхдээ хүмүүжүүлэх Монгол хүний хандлага, Америк хүний хандлага 2 өөр шүү дээ,.. Тиймээс монгол онцлогоо харгалзаж үзэх хэрэгтэй юм.

*Эрдэмтэн, судлаачидтай хийсэн ярилцлагын тэмдэглэлээс*

Бага ангиудын хувьд дагнасан сурах бичигтэй болсон нь багш нарт хөтөлбөр болж байгаа юм. Дунд ангиудын хувьд бид Иргэншил, нийгмийн хичээлүүдтэй холбож, хүн байх, хариуцлагатай иргэн болгож төлөвшүүлэх тал дээр нь илүү анхаарч ажиллахыг хичээдэг. Сургуулийн дүрэм журам, орон нутгийн засаг захиргааны байгууллага, Боловсролын Яамны хэрэгжүүлж буй бодлоготой холбож тухайн үеийн асуудалтай уялдуулж өгдөг. Ийм маягаар өөрсдөө нэг хөтөлбөр боловсруулсан. Тэгэхдээ би үүнийг төгс болсон гэж үзэхгүй. Багш болгон өөрийн дураар орж байснаас дээр. Жишээ нь: Өнгөрсөн жил бид замын хөдөлгөөний дүрэм танилцуулах аян зохиогоод ахлах ангийн сурагчдаар бага ангийн хүүхдүүдэд хичээл заалгаж зурагт хуудас, сануулах заавар самбар дээр гаргасан.

*Сургалтын менежертэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс*

Харин нөгөө талд хэсэг багш нар уг хичээлийн хөтөлбөрийн агуулга нь монголчуудын ёс заншил, уламжлалт үнэт зүйлсийг агуулах ёстой гэжээ. Энэ чиглэлийг барьж буй багш нар монгол хүн, зөв монгол хүн хүмүүжүүлэх тийм агуулга шаардлагатай гэж үзэж байна. Ялангуяа, хотын хүүхдүүд хөдөөнөөс их холдсон. Эх орноо, түүх заншлаа мэддэг, хүндэлдэг болгож хүмүүжүүлэхэд иргэний боловсролын хичээл хэрэгтэй хэмээн өөрсдийн байр суурийг тайлбарласан байна.

Багш бүр тусдаа цаг гаргаж орж байсан, эсвэл ангийн ажил дээрээ, төсөлт цаг гэх мэтээр орж үзсэн. Ингэхдээ Монгол ёс заншил, өв уламжлал эсвэл 1-3 дугаар ангийн сурах бичгийг харж байгаад иймэрхүү юм орвол зүгээр гэж багш нар өөрсдөө хувиргаад оруулдаг. Эсвэл ангид тулгарч буй асуудлыг хүүхдүүдээр өөрсдөөр нь шийдүүлэх, сум орон нутагтаа тулгамдаж буй асуудал юу байна, түүнийг яаж шийдэх талаар өөрсдөөр нь, улс төрч байдлаар санал авч явуулж үзсэн. Ер нь янз бүрийн аргаар явуулж үзсэн.

Тухайн хичээлийн тогтсон хөтөлбөр байхгүй учир тухайн ангид нь тохируулан хичээлээ заадаг байсан. Яамнаас батласан хөтөлбөр байхгүй. Иргэн төслийг их заасан. Хүүхдүүдийг оролцох, өөрсдөөр нь мэдээлэл хайлгах, хүмүүстэй харилцах тал руу нь илүү байвал зүгээр юм. Багш нар бие биенийхээ номноос хэрэгтэй гэсэн юмаа авч заадаг.

10, 11 ангид хичээл заахад сурах бичиг, гарын авлага, хомс ч гэлээ сурагчид мэдээлэл цуглуулах арга зүйгээр сургалтаа явуулж байна. Бага ангид Боржигон өв соёлыг зааж байгаа, аймгийн хэмжээний хөтөлбөр гаргасан. 10-р ангид шашны агуулга орж ирсэн нь учир дутагдалтай байна.

Сэдэв нь улирлаар гардаг болохоор сайн бэлтгэж амжихгүй тал байдаг. Багш нар өөрсдөө л мэдээллээ олж заадаг шүү дээ. Хичээлийн агуулга эмх цэгцгүй байдаг. Үнэлгээ байхгүй. Залгамж холбоо байхгүй нь хүндрэлтэй. Бид нар чинь өөрсдөө л хөтөлбөрөө боловсруулдаг. Тодорхой стандарт байхгүй учир, орон нутгийн түүх, соёлыг үзэж байна. Энэ хичээлийн жилд агуулгыг нэгж хичээлээр гаргасан. Багш нарт агуулгын талаар зөвлөмж, гарын авлага хэрэгцээтэй байна.

*Багш нартай хийсэн ярилцлагын тэмдэглэлээс*

Асуулга судалгаагаар тус хичээлийн агуулгыг бүрдүүлэгч гол үнэт зүйлсийг тодорхойлох зорилго бүхий асуултуудыг асуулгын судалгаанд оролцогч бүлгүүдэд хандан тавьсан болно. Юуны өмнө тус хичээлээр судлах агуулгыг Иргэн хүнд байвал зохих мэдлэг, чадвар, Хүний эрх ба хариуцлага, Монголын уламжлал, өв соёл, ядуурал, байгаль орчны бохирдол зэрэг нийгмийн асуудлууд гэсэн 5 бүлэг зүйлээр сурагчдаас асуухад дээрх бүгдийг хамрах ёстой хэмээн 51,5% нь хариулсан байна. Харин тэдний 28,9% нь зөвхөн “Иргэн хүнд байх мэдлэг, чадвар, дадал”-ын тухай агуулга зонхилох нь зөв хэмээн үзсэн байна. Багш нарын хувьд сурагчидтай маш ойролцоо буюу хичээлээр судлах агуулга нь Иргэн хүнд байвал зохих мэдлэг, чадвар, Хүний эрх ба хариуцлага, Монголын уламжлал, өв соёл, ядуурал, байгаль орчны бохирдол зэрэг нийгмийн асуудлууд гэсэн 5 багц асуудлыг бүхэлд нь хамрах нь зүйтэй хэмээн 50,0% нь хариулсан байна. Үүний хамт 13,3% нь зөвхөн “Иргэн хүнд байх чадвар, дадал”-ын тухай агуулга зонхилох нь зөв хэмээн үзсэн байна. Оюутнуудын хувьд ч мөн бүх асуудлыг бүхэлд нь авч үзэх шаардлагатай гэдэг дээр 42% нь, иргэний чадвар дадлын тухай асуудлыг дагнан судлах шаардлагатай гэдэгт 29,4% нь тус тус саналаа илэрхийлсэн байна. Иймд судалгаанд оролцогчдын хувьд Иргэний боловсрол хичээлийн агуулгыг их өргөн хүрээнд авч үзэж, Иргэний мэдлэг, чадвар, Хүний эрх, үүрэг хариуцлага, Монгол уламжлал, өв соёл, нийгмийн асуудлууд зэргийг цогцоор нь багтаасан байх нь зохистой гэдэгт нэгдэж байна. Ийнхүү агуулгын хувьд өргөн хүрээг хамрахын хамт иргэнд байвал зохих чанар, мэдлэг чадварын тухай асуудлыг бүх бүлгүүд илүү тодотгож байсныг анхаарах хэрэгтэй юм.

Тиймээс дараагийн асуулт нь “Сайн иргэн” байхын тулд шаардлагатай хамгийн чухал чанаруудыг тодотгох явдал байсан юм. “Сайн иргэн байхын тулд та нарын мэдэх, чадах ёстой хамгийн чухал 3 зүйлийг нэрлэнэ үү” гэсэн асуултад суралцагчдын зүгээс дараах 3 хувилбарыг сонгосон байна. Үүнд:

- Сурч боловсрох, хичээлдээ шамдах
- Эрх үүргээ мэддэг, үүрэг хариуцлагаа ухамсарлаж хуулиа дагадаг байх

- Хүмүүжилтэй, харилцааны соёлтой, боловсон байх гэсэн хариултауд дийлэнх хувийг эзэлж байна.

Үүний дараагаар байгаль орчноо хайрлан хамгаалах, Монгол үндэсний түүх соёл, өв уламжлалаас суралцах зэрэг нь удаалж байна. Багш нарын хувьд энэ асуултад эрх, үүрэг хариуцлагаа мэдэж, түүнийгээ хэрэгжүүлэх, харилцааны соёлд суралцах, ёс заншил, өв уламжлалаа мэдэх, хэрэгжүүлэх хэмээн тодорхойлсон нь мөн сурагчдын байр суурьтай тохирч байна. Харин оюутнуудын хувьд харилцааны өндөр ур чадвартай байж, өөрийгөө зөв илэрхийлэхэд суралцах, зөв зан төлөвтэй буюу ёс суртахууны өндөр төлөвшилтэй байх, мэдлэг боловсролоо дээшлүүлэх гэсэн асуудлуудыг илүүтэй онцолсон нь бага зэрэг ялгаатай байна.

*Хүснэгт 3. “Сайн иргэнд байвал зохих 3 гол чанар”*

Сурагчид	Багш нар	Оюутнууд
<b>Иргэний идеал чанарууд</b>		
<ul style="list-style-type: none"> <li>- Сурч боловсрох, хичээлдээ шамдах</li> <li>- Эрх үүргээ мэдэж ухамсарладаг, хуулиа дээдлэх</li> <li>- Хүмүүжилтэй, харилцааны соёлтой байх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- эрх, үүрэг хариуцлагаа мэдэж, түүнийгээ хэрэгжүүлэх,</li> <li>- харилцааны соёлд суралцах</li> <li>- ёс заншил, өв уламжлалаа мэдэх, хэрэгжүүлэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- харилцааны өндөр ур чадвартай байж, өөрийгөө зөв илэрхийлэхэд суралцах</li> <li>- зөв зан төлөвтэй буюу ёс суртахууны өндөр төлөвшилтэй байх</li> <li>- мэдлэг боловсролоо дээшлүүлэх</li> </ul>

Үүнээс харахад судалгаанд оролцогчдын хувьд “Боловсролтой иргэн”, “Хариуцлагатай иргэн”, Харилцааны соёлтой иргэн” төлөвшүүлж хөгжүүлэх нь энэ хичээлийн үр дүнд бий болох гол идеал юм гэдэг дүгнэлтэд хүргэж байна.

Улмаар энэхүү асуултыг нарийвчлан одоо судалж байгаа агуулгын бүрэлдэхүүн хэсгүүд болон цаашид тусгавал зохих үнэт зүйлс, сэдвүүдийг урьдчилан боловсруулж, судалгаанд оролцогчдоор тус хичээлийн хөтөлбөрт тусгавал зохих ач холбогдлоор нь эрэмбэлэхийг хүссэн болно. Үүний дагуу нийт 11 багц сэдвийг оролцогчид бүлэг тус бүрээр эрэмбэлж, дэс дараалалд оруулсан байна. Үүнийг дараах хүснэгтээр харуулав.

*Хүснэгт 4: Иргэний боловсролын хүрээнд судалбал зохих агуулгын эрэмбэ*

	Хөтөлбөрт тусгавал зохих агуулга	Эрэмбэ Сурагчид	Эрэмбэ Багш	Эрэмбэ Оюутан	Эрэмбэ Нэгдсэн
1.	Ардчилал, шударга ёс	39,9 (11)	43,6 (9)	43 (10)	126 (9)
2.	Үндсэн хууль, түүний агуулга	58,7 (8)	48 (8)	56 (8)	163 (7)
3.	Ёс суртахууны онол, сургааль	54,4 (9)	79,8 (4)	83 (6)	217 (5)
4.	Улс төр, төрийн байгуулал	48,1 (10)	25,5 (11)	32 (11)	106 (10)
5.	Хүний эрх, эрх чөлөө	83,1 (2)	77,7 (6)	95 (4)	255 (3)
6.	Орон нутгийн хөгжил, онцлог	65,3 (6)	72,4 (7)	65 (7)	203 (6)
7.	Дэлхийн улс орнуудын хүн ардын амьдрал соёл	61,2 (7)	39,3 (10)	51 (9)	152 (8)
8.	Иргэн хүнд байвал зохих чанар	81,8 (3)	79,8 (3)	100 (1)	261 (2)



9.	Эх оронч үзэл, хандлага	78,9 (5)	85,1 (2)	98 (2)	262 (1)
10.	Монгол хүний зан чанар	80,1 (4)	86,2 (1)	96 (3)	262 (1)
11.	Ёс заншил ба соёлын өв уламжлал	83,3 (1)	79,8 (5)	91 (5)	254 (4)

Энэхүү хүснэгтээс харахад “Иргэний боловсрол” хичээлийн хөтөлбөрт заавал тусгавал зохих агуулгын талаарх байр суурийн хувьд багш нар болон оюутнуудын хувьд адил төстэй бөгөөд улмаар нэгдсэн эрэмбийг гарган үзэхэд дээрх бүлгүүдийн байр суурьтай үндсэндээ адил төстэй дүгнэлт гарч байна. Харин ЕБС-д суралцагчдын байр суурь нь дээрх бүлгийнхнээс бага зэрэг ялгаатай байна. Тэдний хувьд Ёс заншил, өв уламжлал болон хүний эрх, эрх чөлөөний тухай асуудлыг илүү онцлон үзсэн байна. Харин бусад 2 бүлгийн хувьд Иргэнд байвал зохих чанар, Эх оронч үзэл, Монгол хүний зан чанар зэргийг илүү чухалчлан үзсэн байна. Гэвч ерөнхийдөө судалгааны үр дүнгийн хувьд эрэмбийн ялгааг эс тооцвол нийтлэг байр суурь бөгөөд нэг талаас ёс заншил, соёлын өв уламжлал, Монгол хүний зан чанар, нөгөө талаас хүний эрх эрх чөлөө, үүрэг хариуцлага зэрэг иргэн хүний заавал эзэмшвэл зохих чанарууд, тэдгээрийн томъёоллуудтай тохирч байна.

Энэхүү эрэмбэлж буй сэдвүүд ч одоогийн мөрдөж байгаа Иргэний боловсрол хичээлийн сургалтын хөтөлбөртэй зарчмын хувьд нийцэж байгааг тэмдэглэх нь зүйтэй. Мөн Иргэний боловсрол нь суралцагчдад ямар нэгэн шинжлэх ухааны онол, арга зүйн мэдлэгийг дамжуулан олгоход бус харин нийгмийн харилцааны олон талт байдал зэрэг иргэн бүрийн мэдэж, хэрэгжүүлбэл зохих үнэт зүйлсийг өөрийн амьдрал, үйл ажиллагаандаа тохируулан хэрэглэх, үнэлэх, улмаар ухааран ойлгуулахад чиглэдэг тул судалгаагаар гарч буй саналууд нь цаашид зайлшгүй анхаарах, агуулгын баяжуулалтад тусгах оруулах саналууд болж чадна хэмээн үзэж байна.

## **ГУРАВ. СУРАХ БИЧИГ, СУРГАЛТЫН ХЭРЭГЛЭГДЭХҮҮНИЙ ТУХАЙД**

Ярилцлагаар цуглуулсан мэдээллээс үзэхэд зөвхөн хэвлэгдэн гарсан, сургалтад ашиглаж буй сурах бичгээс гадна энэхүү хичээлийн сургалтын хэрэглэгдэхүүний асуудлыг хөндөх нь чухал гэдэг нь харагдлаа. Сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнийг боловсруулахад тухайн хичээлийн зорилго, онцлогийг харгалзах нь чухал юм. Энэ хичээл нь мэдлэгжүүлэхдээ гол нь биш, харин сургалтын хөтөлбөрөөр тодорхойлсон чадвар, дадлыг хэвшүүлэх, дадуулах зорилготой. Ийм учраас аливаа хэрэглэгдэхүүн нь тухайн зорилгыг хангахад чиглэсэн сурагчдын чадвар, дадлыг хөгжүүлэхэд чиглэсэн агуулга, арга зүйтэй байх шаардлагатай.

Бага ангиудын хувьд дагнасан сурах бичигтэй болсон нь багш нарт хөтөлбөр болж байна гэж судалгаанд оролцогчид үзэж байна. Тэдний тэмдэглэснээр сурах бичгийн хувьд их боломжийн, сайн байгаа ч түүнийг хүргэх асуудал багш нарт төвөгтэй байна. Энэ нь багш нарын иргэний боловсролын сургалтын хөтөлбөрийн агуулгын мэдлэг болон идэвхтэй заах арга зүй, танхимаас гадуурх сургалт зохион байгуулах, удирдах ур чадвартай холбоотой гэж үзэж болохоор байна.

Дунд ангиудын хувьд сурах бичиг, гарын авлага байхгүй, сургалтын хөтөлбөр нь багш нарын гар дээр очоогүй, БШУЯ-наас батлан гаргасан нэгдсэн хөтөлбөрийн талаар ойлголтгүй, багш нар өөрсдөө сургалтын материал, мэдээллээ хайж цагаа барж байгаа нь маш их бэрхшээлтэй байдаг байна. Ялангуяа, шинэ, залуу туршлагагүй багш нарт илүү хүнд тусч байна.

Энэ талын гарын авлага ховор, нэмэлт хэрэглэгдэхүүн хэрэгтэй, үлгэр домог унших ном ч гэдэг юм уу, ахлах ангийнханд бол хууль тогтоомж гэх зэрэг унших материал хэрэгтэй л байгаа, Орост, жишээ нь, 9-р ангийн сурах бичиг дээр нь иргэний шүүх ажиллагааны тухай, хэрхэн гомдол, заргаа мэдүүлэх вэ, яаж шийдвэрлүүлэх вэ, хэрхэн мэтгэлцэх гэх мэт зүйлсийг оруулсан байгаа юм. Тэгэхээр энэ хүүхдийн амьдралд хэрэгтэй зүйл байгаа биз, тиймээс иргэний боловсрол хичээл дээр тухайн насны хүүхдэд тулгарч буй асуудал, хүүхдийн сурах онцлог, насанд нь тохирсон гарын авлага зөвлөмж зайлшгүй шаардлагатай. Одоо бол зөвлөмж, гарын авлага бол зөвхөн багш нарт л байгаа. Хүүхдүүдэд зориулсан дасгал ажлын номыг их сонирхон өөрсдөө хийдэг байвал их хэрэгтэй. Их олон янзын хэрэглэгдэхүүн, арга хэмжээнүүдээр иргэний боловсрол хичээлийг бүрэн эзэмшинэ.

*Эрдэмтэн, судлаачидтай хийсэн ярилцлагын тэмдэглэлээс*

Сургалтын үндсэн хэрэглэгдэхүүн болсон сурах бичгийн тухайд бага ангид шинээр гарсан ном хүртээмж муутай, дунд, ахлах ангид сурах бичиг, гарын авлага зайлшгүй хэрэгтэй байгаа нь харагдаж байна.

Сурах бичигт сурагчдын өөрсдөөр нь бие даан хийлгэх, үзүүлэх, дадлагажуулах хичээл маш чухал гэж багш нар үзэж байна. Тухайлбал, захиргааны байгууллагад өргөдөл бичих байлаа гэхэд дасгалын номонд нь загвар өргөдөл байх ба өөрөө доор нь яг дуурайгаад бичих зайтай ч байдаг юм уу, замын хөдөлгөөний тухай гэхэд хамт явдгаар нь баг болгоод өөрсдөөр нь аяллын зургийг нь гаргуулж, энэ аюултай, энэ аюулгүй гэдгийг тэмдэглэх хэсэгтэй байх ч юмуу, эсхүл, багш, цагдаа 2-той хамт хийх аяллын удирдамж ч байж болох жишээтэй. Ер нь бол сурагчийн ном нь мэдээлэл гэхээсээ илүүтэй дадлага ажил голлосон, харин багшийн ном зааварчилгаа байх нь зохистой гэж багш нар үзсэн байна.

1-3 дугаар ангийн сурах бичгүүд чанарын хувьд боломжийн, хүүхдийн сонирхол татахуйц байгаа. 4-р ангийн сурах бичиг дутагдалтай байна. Сурах бичиг үндэсний хэв маягаа хадгалсан сайн сурах бичиг болсон. Нэмэлт зөвлөмж гарын авлага ирсэн. /Чоймаа багшийн/ 1-3 ангид CD ирсэн. 4-5 ангид CD ирээгүй байна.

Энэ сая гарсан CD-ны агуулга яг том хүнд таарсан гэмээр бодит кино байдлаар болохоор хүүхдүүдэд тохиромжгүй, тэрний оронд хүүхдүүдэд зориулсан хүүхэлдэйн кино хэлбэрээр ч юм уу, зурган хэлбэрээр ч юм уу байвал зүгээр болов уу.

*Багш нартай хийсэн ярилцлагын тэмдэглэлээс*

Багш нарт хүүхдийн нас сэтгэхүйд тохирсон тоглоомын аргаар хичээлээ явуулахад нь туслах материал хэрэгтэй байна. Мөн зан заншлын кабинет, үзүүлэн таниулах материал нь сургалтын чухал хэрэглэгдэхүүн болно. Үүнээс гадна багш нарт зориулсан цахим хуудас нь мэдээллийн чухал эх сурвалж болохоос гадна багш нар санал бодол, туршлагаа солилцох, цаг хугацаа хэмнэх зөв шийдэл болно гэж багш нар үзэж байна.

Сурах бичгийн хувьд дутагдалтай, агуулга нь ашиглахаар биш, тэгээд хэдэн сайт хэлдэг, заримдаа түүхэн хүнтэй уулзана гээд тавьсан байдаг, тэгэхээр бидэнд боломж муу.

Бага ангиуд ном сурах бичигтэй, учиртай байдаг. Харин дунд ангийн хувьд тогтсон нэг сурах бичиг байхгүй. Зөвлөмж л гарсан. Өөрсдөө материалаа бэлддэг тул хөдөө орон нутгийн бидэнд хүндрэлтэй байдаг.

*Багш нартай хийсэн ярилцлагын тэмдэглэлээс*

## ДӨРӨВ. БАГШ НАРЫН БЭЛТГЭГДСЭН БАЙДАЛ, МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭЛТ

Иргэний боловсролын хичээлийг анги удирдсан багш нар, технологийн, газар зүйн, түүх, нийгмийн ухааны зэрэг багш нар заадаг байна. Судалгааны мэдээллээс харахад багш нарын бэлтгэгдсэн байдал, мэргэжил дээшлүүлэлт маш чухал болох нь тодорхой байна. Учир нь энэ хичээлийн зорилгыг биелүүлэхэд багш нарт заах арга зүйн, агуулга, хөтөлбөрийн уялдаа холбоо зэрэг олон талын зөвлөмж, зааварчилгаа хэрэгтэй гэдэг дээр бараг бүх багш, судлаач, бодлого боловсруулагчид санал нэгтэй байна. Иймээс багш болон тэдний мэргэжил дээшлүүлэх асуудлыг нэг хэсэг болгон энэхүү хэсэгт оруулж байна.

Одоогийн байдлаар тухайн зааж байгаа багшаас их юм хамаарч байгаа. Тухайн багш хэр туршлагатай, хэр сэтгэлтэй, хичээлийн агуулга зорилгыг хэр сайн ойлгож хүүхдүүдэд хүргэж байна гэдгээс бас их шалтгаалж байгаа юм.

*Сургалтын менежертэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс*

Иргэний боловсролын хичээлийг зааж байгаа багш нарыг давтан сургах шаардлагатай байна. Олонх аймаг, нийслэлийн сургуулиудад шинэ хичээлийн жил эхлэхээс өмнө иргэний боловсрол заах бүх багш нартаа 3 хоногийн сургалт явуулдаг. Гэвч бүтэн жил заах хичээлийг зохион байгуулах багш нарыг 3 хоногийн сургалтаар мэргэшүүлэх зорилт тавьсан нь учир дутагдалтай байна. Үүний хамт багш нарт хэрэглэх CD, арга зүйн зөвлөмж боловсруулж өгдөг. Энэ 2 хэрэглэгдэхүүнээс өөр нэмэлт материал багш нарт байхгүй байна. Иймд цаашид тухайн хичээлийг зааж буй багш нарыг ээлж дараагаар нь давтан бэлтгэх шаардлагатай бөгөөд үүнд ихээхэн хөрөнгө, мөнгөн тусламж шаардлагатай байдаг.

*БШУЯ-ны мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс*

Иргэний боловсролын хичээлийг зааж буй багш нарын мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагаа бага, дунд багш нарын аль алиных нь хувьд хангалтгүй гэдэгтэй ярилцлагад оролцсон бүх бүлгийн төлөөлөл санал нэгтэй байна. Ялангуяа, багш нар иргэний боловсролын багш нарын мэргэжил дээшлүүлэлт бараг байхгүйтэй адил, харьяалах боловсролын байгууллага нь тэдэнд зөвхөн сургалтын хөтөлбөрөө танилцуулсан төдийгөөр хязгаарлагддаг гэдгийг хэлж байна. Энэ нь бага ангийн багш нарын тухайд маш их яригдсан бөгөөд монгол хэл, математикийг түлхүү ярилцаад, иргэний боловсролыг бол цухас дурдаад өнгөрдөг байна.

Аймагт болдог семинар бусад хичээлээр явагдаж байсан. Иргэний боловсролыг цухас дурдаад өнгөрдөг. Шинэ сурах бичиг гаргаад тэрнийхээ заах арга болон мэргэжил дээшлүүлэх сургалтууд явуулж баймаар байна. Тэгвэл илүү үр дүнтэй болно доо.

Манай сургуулийн багш нар аймагт болдог сургалт семинарт хамрагддаг, гэхдээ энэ талын сургалт ерөөсөө болж байгаагүй. Ялангуяа шинэ арга барил, заах аргын сургалт хэрэгтэй. Багш нар ийм сургалтаар дутагдаж байгаа шүү. Лекц унших биш, яг заах аргын сургалт байвал чухал.

Уг сурах бичгийг зохиосон хүмүүсээр нь сургалт явуулж болдоггүй юм уу. Тэр хүмүүс яг юуг хүсэж энэ номыг хийснийг бид мэдэх хэрэгтэй. Зүгээр нэг ном ирдэг. Бусад нь тодорхойгүй. Тэр зохиогч нараар нь заалгавал үр дүнтэй, сонирхолтой сургалт болно байх даа.

*Багш нартай хийсэн ярилцлагын тэмдэглэлээс*

Багш бэлтгэгдээгүй нь үнэн. Хүүхдээр нь дамжуулан судлахад 1, 2 ангийн хүүхдүүд иргэний боловсрол бараг ордоггүй гэж хэлж байсан. Энэ нь зарим багш нар энэ хичээлийн ач холбогдолыг сайн үнэлж чадахгүй байгаа нь харагдаж байна. Хөтөлбөрийн багш ноднингоос л зөвлөмж, CD хэрэглэгдэхүүнээр дамжуулж өөрсдийгөө хөгжүүлэхэд нь туслах зорилгоор гаргасан. Багш нарын мэргэжил дээшлүүлэхэд илүү анхаарах хэрэгтэй, бүр графикт сургалтуудыг зохион байгуулах гэх мэтээр системтэйгээр дээшлүүлэх хэрэгтэй.

*Эрдэмтэн, судлаачидтай хийсэн ярилцлагын тэмдэглэлээс*

Ярилцлагаар цуглуулсан мэдээллээс үзэхэд тухайн хичээлийн багш нарын мэргэжил дээшлүүлэх ажлыг ТББ буюу иргэний нийгэмийн байгууллагууд л гүйцэтгэдэг гэж дүгнэж болохоор байна. Тэднээс зохион байгуулсан сургалт багш нарт илүү хүрч, сургалтдаа ашигладаг байна.

Бид энэ хичээлийг танхимын бус хэлбэрээр явуулахыг хүсч байна. Гэвч долоо хоногт нэг удаа, 40 мин ордог тул ерөөсөө амждаггүй, сургалтын менежер ч зөвшөөрөхгүй.

*Багш нартай хийсэн ярилцлагын тэмдэглэлээс*

Иргэний боловсрол төвийн “Иргэн” төслийн сургалт маш их үр дүнтэй байсан. Сурах бичигтээ энэ “Иргэн” төслийг нэг бүлэг нь болгоод оруулбал их өгөөжтэй байх болов уу. Хүүхдүүдийг маш их хөгжүүлдэг учраас. Ер нь энэ иргэний боловсрол хичээлийг үр дүнтэй явуулахыг хүсвэл хамгийн чухал нь багшийн сургалтуудыг сайн явуулж, багшаа сайн бэлтгэх хэрэгтэй.

93-р сургуулийн багш Батцэрэн багшийн “Хүн байхын үндэс” гэдэг сургалтад суусан. Зөв үг хэлж, сайн хүн байх гэх мэтийг заасан, их үр дүнтэй сургалт байсан.

*Багш нартай хийсэн ярилцлагын тэмдэглэлээс*

## **ТАВ. ИРГЭНИЙ БОЛОВСРОЛ БА ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГА**

Иргэний боловсролын асуудал бол долоо хоногт нэг цагийн хичээлийг танхимд судласнаар шийдэгдэх асуудал биш юм. Тийм ч учраас бид энэхүү судалгааны хүрээнд хүүхдийг хөгжүүлэх, ардчилсан иргэний нийгмийн үнэт зүйлсийг түгээн дэлгэрүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэний нийгмийн байгууллагын төлөөллөөс иргэний боловсролтой холбоотой мэдээлэл цуглуулсан билээ.

Мэдээж чухал. Би бол 80-д оны сурагч. Тэр үед бид нарт тоо, томьёо л цээжлүүлж байсанаас биш энэ хурдтай нийгэмд яаж бусадтай хамтрах, яаж хөгжих вэ гэдгийг заагаагүй.

*ТББ-ын төлөөлөлтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс*

Иргэний боловсролын чиглэлээр өөр, өөрийн хувь нэмрийг оруулж буй ТББ-ууд нь иргэний боловсрол гэдэг хичээл нь хүний ур чадварыг дээшлүүлдэг, нийгэмд хэрхэн зохицож амьдрах тухай хүүхэд залуучуудад зааж өгдөг, орчин цагийн зөв хүн байх, мөн уламжлал түүх соёлоо мэддэг хүн болоход нь чиглэгдсэн агуулгатай байх нь зүйтэй гэж зөвлөж байна. Мөн тэд

сургууль, иргэний нийгмийн хамтын ажиллагааны өргөн боломжийг ашиглахыг санал болгож байна. Тухайлбал, тэдний үзэж байгаагаар, иргэний боловсрол хичээл боловсролын системд ороод явах бол нэг хэрэг, тэрийг илүү хүүхдийн оролцоотойгоор, сонголттойгоор дээрээс нь тэдний төлөө үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудыг оролцуулан илүү үр дүнтэй явуулах боломж байгааг тэмдэглэж байна. Энэ нь багш нарын хувьд танхимаас гадуур сургалтыг зохион байгуулах таатай боломж бөгөөд үүний тулд оновчтой менежментэд тулгуурласан хамтын ажиллагааг зохион байгуулах шаардлагатай.

Иргэний нийгмийн байгууллагын анхаарал хандуулсан нэг асуудал нь иргэний боловсрол гэдэгтээ юуг багтааж байгаа, юуг ойлгож байгаагаа их сайн хэлэлцүүлсэн эсэх тухай асуудал байна. Үүнд ардчиллын боловсрол, сонгогчдын боловсрол, уламжлал, зан заншил гэх мэт асуудлыг яаж тусгаж ойлгох, алийг нь хамааруулах, алийг нь хамааруулахгүй вэ, эрх зүйн асуудал багтах уу, үгүй юу гэх мэт. Тэдгээр ойлголтуудыг сайн нэгтгэсний дараа хөтөлбөрөө боловсруулах ажилаа хийх хэрэгтэй. Хэт задгай байвал хэцүү байх, хэт өрөөсгөл байвал бас болохгүй гэх зөвлөмж байлаа.

Нэг сургууль 2000-3000 гаруй хүүхэдтэй гэж бодоход нэг хэсэг нь Улаан Загалмайн үйл ажиллагаанд нэгдээд анхны тусламжийн мэдлэгтэй, гамшиг ослын үед авах арга хэмжээг мэддэг больё, өөрийн байгаа орчиндоо хүмүүнлэг энэрэнгүй зөв хүн болоход чиглэгдсэн талыг сонирхож байгаа хүүхдүүд ордог. Тэгвэл Скаутын холбоо гэхэд илүү аялал зугаалга, адал явдалд дуртай хүүхдүүд нэгдье гэдэг. Харин Сурагчдын холбоо гэхэд лидер сурагчдыг бэлтгэнэ, би өөрөө лидер болно, илтгэх урлагаар явна гэх мэт байгууллага болгон өөр өөрийн чиглэлтэй байдаг. Үүнийг хүүхдүүдэд сонголттойгоор оруулах /Иргэний боловсрол хичээлийн хүрээнд/, яг энэ бүхнийг сур гэхээсээ илүү энийг сурахад энэ байгууллагад элсэн ор гэдэг ч юм уу, багш заавал заах шаардлагагүй, тэр байгууллагууд нь очиж мэдээлэл өгдөг ч юм уу, төсөл хөтөлбөр хэрэгжүүлдэг ч юм уу, ямар ч байсан олон талын хамтын ажиллагаа явуулах боломж нь бүрдэнэ.

Тэгснээрээ хүүхдүүд олон сонголттойгоор хичээлийн цагаар, хичээлийн бус цагаар багштайгаа хамтраад, найз нөхөд, бүлгээрээ хамтраад бусад мэргэжлийн байгууллагуудтай хамтраад оролцох боломжтой. Тэрийг энэ хөтөлбөрт нь тусгаж өгөх юм бол сургуулийн удирдлагууд ч ойлголттой болно. Энэ нь тэр байгууллагууд үйл ажиллагаа явуулахад ч тус болж өгнө. Ер нь бол дандаа компанчилдаг байсан, орох ёстой гээд л, тэр нь тэгээд сураад байгаа ч юм уу үгүй юу, тэрийгээ яаж ч үнэлдэг юм. бид энд их шүүмжлэлтэй ханддаг байсан. Гэвч өөрчилж чадахгүй л байна.

*ТББ-ын төлөөлөлтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс*

Сонголттой, нээлттэйгээр өөрсдөө юмаа эрж хайж, оролцож, бусдад таниулж, хамтран хийж, ахмад хүнийг урьж гэх мэтээр оруулбал хүүхдүүд тэр хичээлийг хүсэн хүлээдэг болно. Тэгэхгүй бол бүх хичээл нь өглөөнөөс эхлээд л онолдоод, суулгаад байдаг юм чинь нэг хичээл нь яагаад тийм байж болохгүй гэж. Тиймээс агуулгыг нь яаж хүргэх, хэрэгжүүлэх арга зүйн асуудал нь л их чухал байна. Мөн энэ чиглэлээр мэргэшсэн байгууллагуудыг оролцуулан том хэлэлцүүлэг хийж байгаад хөтөлбөртөө юу тусгахаа хэлэлцэж оруулж болно. Сургуулиудыг түшиглэн үйл ажиллагаагаа явуулдаг их олон байгууллага байдаг. Хүүхдийн эрхээр, хүүхдийн оролцоогоор, хүүхдийн хөгжлөөр гэх мэт.

*ТББ-ын төлөөлөлтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс*

ТББ-уудын нэг анхаарал хандуулж буй асуудал нь багш нар, тэдний ур чадварын асуудал байна. Тухайлбал, сонгогчдын боловсролын хөтөлбөрийг боловсруулаад юуны өмнө нийслэлийн багш нарыг сургасан байна. Учир нь сургалтын хөтөлбөрийг боловсруулсан хүмүүс

бус багш нар л сурагчдад хүргэдэг тул тэдний дэмжлэггүйгээр, оролцоогүйгээр үр дүн гарахгүй гэж үзсэн байна. Аль ч ТББ-ын хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийн хүрээнд багш нарыг дэмжих явдал чухал байр суурь эзэлж байгаа нь эдгээр байгууллагуудтай хамтран багш нарын мэргэжил дээшлүүлэх ажлыг зохион байгуулах боломжтойг харуулж байна. Тийм ч учраас иргэний нийгмийн байгууллагууд уламжлалт болон орчин үеийн гэсэн 2 агуулгаа хэрэгжүүлэхэд тэр чиглэлээр мэргэшсэн байгууллагуудыг татан оролцуулах замаар хамтрах боломжийг олгох хэрэгтэй гэж үзэж байна.

Судалгаанаас үзэхэд сурагчдын иргэний чадварыг хөгжүүлэхтэй холбоотой нэмэлт хөтөлбөр, чөлөөт цагийн үйл ажиллагааг сургуулийн зүгээс туйлын хангалтгүй зохион байгуулдаг нь харагдаж байлаа.

*Хүснэгт 5: Сургууль дээрх нэмэлт хөтөлбөр, чөлөөт цагийн үйл ажиллагааны хэлбэрүүд*

№	Үйл ажиллагааны төрлүүд	Хувь
1.	Нийгмийн туст хөдөлмөр эрхлэх	52%
2.	Сурагчдын өөрөө удирдах байгууллага байгуулах, үйл ажиллагаанд нь оролцох	20,6%
3.	Багш, эцэг эх, сурагчдын өдөрлөг зохион байгуулах	8,7%
4.	Нутгийн удирдлагын ордон, төрийн байгууллага, шүүхтэй танилцах	1,6%
5.	Төрийн албан хаагч, улс төрчид, иргэдтэй уулзалт, ярилцлага зохион байгуулах	2,7%
6.	Мэтгэлцээн болон илтгэл тавих	4,6%
7.	Ийм боломжууд огт байдаггүй	8,1

Дээрх хүснэгтийн мэдээллээс үзэхэд манай сургуулиудын хувьд нийтийг хамарсан цэвэрлэгээ, тусч аян зэрэг хичээлээс гадуурх уламжлалт үйл ажиллагаанууд зонхилсон хэвээр байгааг илтгэж байна. Харин ч суралцагчдын зүгээс эдгээр үйл ажиллагааг өөрсдийн иргэний чанар, чадварыг хөгжүүлэхтэй холбоотой арга хэмжээ хэмээн үзэж, үнэлж байгаа нь сайшаалтай гэж болохоор байна. Гэтэл сургуулиуд дээрх сурагчдын өөрийн удирдлагын байгууллагын үйл ажиллагаанд сурагч бүрийг татан оролцуулах, сургуулийн удирдлага, захиргаа, багш нартайгаа хамтран шийдвэр гаргадаг, хэрэгжүүлдэг байх, мөн нутгийн захиргааны болон төрийн бусад байгууллага, албан газруудаар уулзалт, танилцах аялал хийх, мэтгэлцээний болон бусад хэлбэрийн тэмцээн уралдаан зохион байгуулах зэргээр хичээлийг шинэлэг арга хэлбэрээр, өргөн хүрээнд зохион байгуулах санаачлага хомс байгааг харуулж байна. Үүнээс үзэхэд багш, судлаач, мэргэжилтнүүдийн ярилцлагын судалгаанд гарч байсанчлан “баахан онолын хичээл заагаад тухайн хичээлийн цаана ямар үр өгөөж, хэрэглээ, төлөвшил байх ёстойг анхаарахгүй орхигдуулж байна уу даа” гэсэн болгоомжлолыг нотлон харуулж байна. Ийм үед иргэний нийгмийн байгууллагуудын санал, санаачилга нь ялангуяа, хичээлээс гадуур, танхимын бус сургалтаар иргэний боловсрол олгоход үнэтэй хувь нэмэр оруулах юм.

## ДҮГНЭЛТ, САНАЛ

Иргэний боловсролын сургалтын хөтөлбөр, түүний хэрэгжилтийн талаарх багш, боловсролын удирдах ажилтан, арга зүйчид, судлаачидтай хийсэн ярилцлага, сурагч, багш нар, багш мэргэжлээр суралцаж буй оюутнуудаас авсан асуулгын дүнд үндэслэн Иргэний боловсролын сургалтын хөтөлбөрийн талаар дараах бүрэлдэхүүн хэсгээр дүгнэлт, санал зөвлөмжийг боловсруулав. Үүнд:

- **Бодлого, түүний хэрэгжилт** – БШУЯ-наас батлан гаргасан бодлого, дүрэм журам түүнийг хэрэгжүүлэх, боловсронгуй болгох алхмууд болон бусад нийгэм эдийн засгийн нөлөөлөл
- **Сургалтын хөтөлбөр, агуулга** – Иргэний боловсрол хичээлийн хөтөлбөр, түүний бүрэлдэхүүн хэсгүүд болох хичээлийн зорилго, агуулга, заах арга зүй, хөтөлбөрийн үнэлгээ, үнэт зүйлсийн тогтолцоо
- **Багш нарын мэргэжлийн бэлтгэл** – Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж хүлээгдэж буй үр дүнд хүрэхэд шаардлагатай багш нарын мэргэжлийн бэлтгэл, тасралтгүй байдал, залгамж чанар зэрэг болно. Үүнд: хичээлийн хөтөлбөр, холбогдох материалыг боловсруулах, мэргэжлийн буюу бусад боловсролын хэрэглэгдэхүүн, сургалтын материалуудыг хэрэглэх, бүтээх байдал зэргийг авч үзнэ.
- **Хяналт, үнэлгээ** – Тухайн хичээлийн чанар, үр өгөөж, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд тасралтгүй хяналт тавих, холбогдох талуудын оролцоо, хариуцлагыг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлэх
- **Иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагаа** – Иргэний боловсролыг түгээн дэлгэрүүлэхэд ИНБ/ТББ-дын үүрэг оролцоо, танхимын бус сургалтын зэрэг шинэлэг арга хэлбэрүүдийг нэвтрүүлэх, багш нарыг бэлтгэх, давтан бэлтгэхэд хамтран ажиллах зэрэг болно.

Өөрөөр хэлбэл, иргэний боловсролыг чанаржуулахын тулд дараах асуудлуудыг сайтар анхаарах, дахин судлан шинжлэх, бодлого, арга зүйн хэрэглэгдэхүүнүүдийг боловсруулах шаардлагатай болох нь нэн тодорхой байна. Үүнд: а) Иргэний боловсрол нь бусад хичээл сургалт, тэдгээрийн сургах болон суралцахуйн арга хэлбэр, хандлагаас чухам юугаараа ялгаатай вэ, б) Иргэний боловсролын агуулга, хөтөлбөрөөр тодорхойлсон мэдлэг, чадвар, үнэт зүйлсийг төлөвшүүлэхэд сургуулийн аль нас, үе шатууд илүү тохиромжтой байх вэ?, в) Иргэний боловсролын сургагч багш нарыг бэлтгэх, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэхэд ямар нэгэн арга зүй, шинэлэг хандлага хэрэгтэй юу, г) Иргэний боловсролын хүрээнд үнэлгээний ямар арга хэлбэр, зарчмыг баримталбал зохих вэ? зэрэг болно.

#### **Бодлого, түүний хэрэгжилт:**

“Иргэний боловсрол”-ын үзэл баримтлал нь өргөн цар хүрээтэй тул түүний хүрээнд хүний болон нийгмийн хүрээлэн буй орчинг бүхэлд нь авч үзэж, нийгмийн өөрчлөлт, харилцан хамаарал, ялгаа, эрх үүрэг, ардчилал, хөгжил, нийгмийн баялаг, тогтвортой байдал болон даяаршил гэх мэт асуудлыг хамруулан үздэг байна. Суралцагчид Иргэний боловсролыг эзэмшсэнээр хариуцлагатай байх үнэт зүйл, хандлагыг өөртөө бий болгож, нийгмийн амьдралд идэвхитэй оролцох чадвар дадалтай болдог. Тийм ч учраас Боловсролын тогтолцоонд судалж буй хичээлийн хөтөлбөрүүдэд Иргэний боловсролыг ерөнхий болон нарийвчилсан хэлбэрээр хэрхэн уялдуулан оруулах, үр дүн, чанарыг сайжруулах нь ихээхэн хүнд, бөгөөд цаг хугацаа, хүчин чармайлт шаардсан ажил болох нь харагдаж байна.

Иргэний боловсролыг сурагчдад эзэмшүүлэх гол хөдөлгүүр нь одоогийн ЕБС-ийн сургалтын хөтөлбөрт тусаад буй Иргэний боловсрол хичээл хэвээр байна. Иргэний боловсролын хичээлийг тухайн боловсролын түвшний хэрэгцээ шаардлага, агуулга, арга зүйн боловсруулалтыг дахин нягталсаны үндсэн дээр одоо байгаа хичээлийн хөтөлбөрүүдээр дамжуулан зааж болно. Ингэсэн тохиолдолд сургууль нь Иргэний боловсролыг цогц байдлаар хүргэх гол институт хэвээр байх нь тодорхой харагдаж байна.

Иргэний боловсрол хичээлийн зорилго нь Иргэн болон төлөвшүүлэх явдал гэдэгт манай боловсролын харилцаанд оролцогчид бүрэн санал нэгдэж байна. Нэгэнт Иргэн болох үйл явц, түүний төлөвшлийн тухай ойлголт нь өргөн хүрээний үзэл баримтлал тул эх оронч үзэлтэй болгох, ёс заншил, өв уламжлалаа мэдэх, хүндэтгэх, хамгаалах, хууль дүрэм, эрх үүргээ мэддэг хариуцлагатай иргэн болгох, нийгмийн харилцаанд зөв шударга, эрх чөлөөтэй оролцоход нь туслах, зорилго тэмүүлэлтэй, түүндээ хүрэх эрмэлзэлтэй болгох зэрэг олон тооны хариултын хувилбарууд гарч байсан нь дээрх үндсэн зорилгыг дэмжихүйц агуулгын талаарх саналууд гарч байна.

Иргэний боловсрол эзэмшсэнээр сурагч нь өөрт байх ёстой үнэт зүйлийг мэдэж аваад, амьдралдаа хэрэгжүүлэх боломжтой болно. Гэхдээ иргэний боловсролтой холбоотой асуудлуудыг нарийвчлан тодорхойлох шаардлагатай. Асуудлуудыг тодорхойлох боломж шууд өгөгдөөгүй байгаа нь багш, сурагч болон мэргэжилтнүүдийн зүгээс өөр өөрийн нөхцөл байдалд тулгуурлан заах, сургах улмаар зорьсон үр дүндээ хүрэх магадлалыг бууруулахад хүргэж байна. Иймд Иргэний боловсролын сургалтын хүрээнд түүний агуулга, арга зүй, үнэлгээ болон багш нарын мэргэжил дээшлүүлэх, давтан сургах чиглэлийн сургалт, судалгаанууд нэн шаардлагатай болох нь харагдаж байна. Эдгээрээс юуны өмнө иргэний боловсрол гэдэг ойлголтыг тодорхойлох үзэл баримтлал, улс орны хувьд иргэний боловсрол хичээлээр суралцагчдад юуг эзэмшүүлж, ямар мэдлэг чадвартай болгох тухай нэгдсэн ойлголт энэ чиглэлээр ажилладаг бүх субъектүүдэд хэрэгтэй байна. Энэ нь орчин үеийн боловсрол судлал, сурган хүмүүжүүлэх ухааны үндэстэй, мөн бусад улс орнуудын сайн туршлагад тулгуурласан байвал зохино. Өөрөөр хэлбэл, яг иргэний боловсрол гэдэгт юуг багтааж, юуг ойлгож байгаагаа нийт оролцогчдын дунд сайн хэлэлцүүлэх хэрэгтэй байна. Үүнд ардчиллын боловсрол, сонгогчдын боловсрол, уламжлал, зан заншил зэргээ хэрхэн тусгах, алийг нь хамааруулах, зэргээр эдгээр ойлголтуудыг сайн нэгтгэсний үндсэн дээр хөтөлбөрөө боловсруулах шаардлагатай болохыг судалгаанд оролцогчид онцолж байна.

Ялангуяа БШУЯ-ны зүгээс Боловсролын хүрээлэн, судалгааны байгууллагууд болон бусад олон улсын байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагуудыг хамруулан нэгдсэн зохицуулалттайгаар тухайн боловсролын агуулга, арга зүйг сайжруулахад цогц байдлаар хандах шаардлагатай байна. Үүний тулд холбогдох бүх талуудыг оролцуулан тухайн боловсролын талаар баримтлах бодлого, хэтийн төлөвийг тодорхойлж, цаашид хөтөлбөрийн шинэчлэлт, сургалтын чиглэл, нөөц хэрэглэгдэхүүн боловсруулах, үнэлгээ дүн шинжилгээ хийх хүрээг тогтоон ажиллах нь зүйтэй. Иргэний боловсролын талаар бодлогын ба практик хүрээг тодорхойлсон цогц баримт бичиг нэн даруй боловсруулахыг зөвлөж байна. Энэхүү баримт бичиг нь тухайн боловсролын зорилго, шинэчлэх хэрэгцээ шаардлага, агуулгын сэдэв, анхаарах асуудлууд, сургалтын хөтөлбөр, мэргэжил дээшлүүлэх, үүнд эцэг эх, олон нийтийг оролцуулах, багш бэлтгэх боловсролын тухай зэрэг асуудлыг тусгах шаардлагатай.



**Сургалтын хөтөлбөр, агуулга:**

Иргэний боловсролын сургалтын гол тулгамдсан асуудал нь сургалтын хөтөлбөр, түүний агуулга, арга зүйн асуудал байна гэж үзэж болохоор байна. Энэ хичээл 2006 оноос сургалтын хөтөлбөрт тусгагдсан боловч чухам юу тусгах, хэрхэн заах, үнэлэх тухай асуудал тодорхойгүй, сургууль тус бүр өөрсдийн нөхцөл байдлын хүрээнд алдаг оног ордог байсантай харьцуулахад сүүлийн хоёр жилд Иргэний боловсролын хөтөлбөр түүний агуулга тодорхой болж байна. Өөрөөр хэлбэл, 2011 оноос Иргэний боловсрол хичээлийн ерөнхий хөтөлбөр, зөвлөмж, мөн 1-5 ангийн сурах бичгүүд, түүнийг хэрэглэх зөвлөмжүүд боловсруулагдан гарсан байна.

Үүний хамт Иргэний боловсрол хичээлийн үнэлэмж ихээхэн дээшилсэн нь энэхүү судалгааны дүнгээс тодорхой харагдаж байна. Уг хичээлд төдийлэн ач холбогдол өгдөггүй, “алдаг оног” ордог, зарим сургуульд бүр ордоггүй байсантай харьцуулахад сүүлийн 2 жилийн хувьд харьцангуй тогтвортой орох болсон бөгөөд энэ нь тухайн хугацаанд төр засгаас явуулж буй бодлого<sup>1</sup>, сургуулийн удирдлагын зүгээс үзүүлж буй дэмжлэг зэрэгтэй холбоотой гэж үзэж болохоор байна. Гэвч энэ байдал нь уг хичээлийн чанар дээшилсэн гэдгийг илтгэхгүй бөгөөд зарим сургуулийн бага ангид уг хичээлийг заадаггүй, заасан ч чанаргүй байгааг .

Энэхүү судалгааны явцад “Иргэний боловсрол” хичээлийн хөтөлбөрт заавал тусгавал зохих агуулга, ойлголтын цөмийг тодорхойлох ажлыг сурагч, багш, оюутан 3 бүлгийн оролцогчдоор хийлгэсэн. Үүний үр дүнд Иргэний боловсролын хөтөлбөрийн хүрээнд сурагчдын мэдвэл зохих мэдлэг, чадвар, үнэт зүйлсийн талаар дараах агуулгын эрэмбэ гарсан болно. Үүнд:

1. Эх оронч үзэл, хандлага
2. Монгол хүний зан чанар
3. Иргэнд байвал зохих чанар
4. Хүний эрх, эрх чөлөө
5. Ёс заншил, соёл, өв уламжлал
6. Ёс суртахууны онол, сургааль
7. Орон нутгийн хөгжил, онцлог
8. Үндсэн хууль, түүний агуулга
9. Дэлхийн улс орнуудын хүн ардын амьдрал, соёл
10. Ардчилал, шударга ёс
11. Улс төр, төрийн байгуулал

Үүнээс харахад судалгаанд оролцогчдын хувьд эх оронч үзэл, Монгол хүн, түүний өвөрмөц байдал, бахархал зэргийг тус хичээлийн хүрээнд нэн тэргүүнд судлах ёстой хэмээн онцолсон байна. Энэ нь сүүлийн үед манай улсад ихээхэн хөндөгдөх болсон үндэсний үзэл, үндэстэн өөрийгөө тодорхойлох, ижилсэх зэрэг үйл явцын шууд үр дагавар, нөлөөлөл хэмээн үзэж байна. Үүний хамт түүхэн уламжлал, соёл болон ёс суртахууны асуудлуудыг 5-6 эрэмбэд гаргаж тавьсан нь мөн Монголчуудын үндэсний ухамсрын сэргэлттэй шууд холбоотой гэж үзэж болно.

Мөн хүний эрх, эрх чөлөө, иргэнд байвал зохих чанар, зэргийг 2-3 дугаарт эрэмбэлсэн нь манай боловсролын тогтолцоонд ялангуяа түүх, нийгмийн ухааны сургалтын агуулгын шинэчлэлийн хүрээнд дээрх асуудлуудыг өргөн хүрээнд авч үзэх болсон, нөгөө талаас иргэний оролцооны

<sup>1</sup> МУ-ын Ерөнхийлөгчийн зарлиг гарсан. 1-3 дугаар ангийн сургалтын хөтөлбөр, сурах бичиг, багш нарт зориулсан зөвлөмж хэвлэгдэж багш, сурагчдын гарт очсон

түвшин, иргэдийн хүний эрхийн боловсрол тодорхой хэмжээнд дээшилж буйтай холбоотой байх талтай. Харин Үндсэн хууль, дэлхийн улс орнуудын амьдрал, соёлын тогтолцоо, ардчилал, шударга ёс, улс төрийн байгуулал зэрэг ойлголтуудыг 8-11 дүгээрт эрэмбэлэн үзсэн нь дээрх асуудлууд ЕБС-ийн Нийгмийн ухаан, Түүх, Газарзүй зэрэг бие даасан хичээлүүдээр дэлгэрэнгүй үзэж судалдаг тул дээр дурдсанчлан агуулгын давхардал гаргахаас сэргийлсэнтэй холбоотой гэж үзэж байна.

Гэхдээ судалгаанд оролцогчдын хувьд дээр дурдсанчлан, иргэний боловсролын гол зорилго нь суралцагчид, өсвөр үе, залуучууд өөрсдийн эрх, эрх чөлөөгөө мэдэх, шийдвэр гаргахад оролцох, үзэл бодол, байр сууриа илэрхийлэх зэргээр хариуцлагатай, бие даасан нийгмийн гишүүн болон төлөвшихэд дэмжлэг үзүүлнэ гэдэгт санал нэгдсэн болно. Энэ нь дэлхийн улс орнуудыг иргэний боловсролын сургалтын хөтөлбөрт дараах 4 үндсэн харилцааг тусгахыг зөвлөмжилсөн ЮНЕСКО-ийн зөвлөмжтэй зарчмын хувьд нийтлэг байна гэж үзлээ. Уг зөвлөмжид:

1. Хувь хүн ба нийгмийн хоорондын харилцаа
2. Иргэн ба төрийн хоорондын харилцаа
3. Иргэн ба ардчилсан ёсны хоорондын харилцаа
4. Иргэний эрх ба үүргийн хоорондын харилцаа нь “Иргэний боловсрол” хичээлийн агуулгыг бүрдүүлэх тухай заасан байдаг<sup>2</sup>.

Үүнээс дүгнэн үзэхэд Иргэний боловсрол хичээлийн хөтөлбөрийн агуулга нь “Монголчуудын үндэсний өв соёл, уламжлалт зан үйл” болон “Орчин цагийн иргэний боловсрол” гэсэн хоёр үндсэн аятай байхыг судалгаанд оролцогчдын зүгээс дэмжиж байна. Харин сургалтын хөтөлбөрийн агуулгыг бага ангид нь монгол ёс заншил, өв уламжлал, дунд ангид нь хүний эрх, эрх чөлөө, ахлах ангид нь олон улсын харилцаа, ардчилал, ардчиллын үнэт зүйлс гэх мэтээр тодорхой ялгаж, улмаар хичээлийн цаг, агуулгын багтаамжийг зохистой гаргасан хөтөлбөр боловсруулахыг багш нарын зүгээс хүсэж байна.

Сургалтын хөтөлбөрийг боловсруулах болон боловсронгуй болгохтой холбоотой багш нарын саналыг нэгтгэж үзэхэд дараах дүр зураг харагдаж байна. Үүнд:

Иргэний боловсролын сургалтын хөтөлбөр агуулгын хувьд давхардалтай байна, тиймээс үүнийг нэг мөр болгох хэрэгтэй. Тухайлбал:

- Бусад хичээлийн хөтөлбөртэй буюу ниймийн ухааны болон түүхийн хичээлийн агуулгатай давхардаж байна.
- Тухайн хичээлийн хүрээнд ангийн түвшинд мөн агуулгын ихээхэн давхардалтай байна. Ялангуяа, орон нутгийн боловсролын байгууллагаас боловсруулан багш нарт түгээсэн сэдэв хөтөлбөрүүд давхардсан, ялангуяа 7-11 ангийн хувьд бүх ангид хөтөлбөр нь адил байдаг, тэгэхээр дараа жил нь дахиад л орох болдог, түүх, нийгмийн ухааны хичээл дээр заадаг зүйлийг ч оруулсан байдаг зэргээр тухайн хичээлийг зааж буй багш нарын зүгээс ихээхэн шүүмжлэлтэй хандаж байна.

Энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд:

- Нийгмийн ухааны болон түүхийн зэрэг бусад хичээлийн агуулгаас ялгах
- Дотроо давхардаад байгаа агуулгын гүнзгийрэл болон өргөжилтийг нарийвчлан гаргаж өгөх шаардлагатай. Өөрөөр хэлбэл, агуулга давхардуулахгүй байх нэг арга нь дараалсан, шат шатаар ахисан байхаар боловсруулах хэрэгтэй байна.

<sup>2</sup> Civics education for the twenty-first century <http://portal.unesco.org/education/en> 2006-08-26

- Мөн багш нарын зүгээс сурагчдын оролцоонд тулгуурлан хэрэгжүүлэхүйц сургалтын хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэхийг хүсэж байна.
- Зарим багш нарын хувьд иргэний боловсролын хичээлийг танхимаас гадуур зохион байгуулах сургалт, хүмүүжлийн үйл ажиллагааны хэлбэрээр зохион байгуулахыг хүсэж байна. Гэвч энэ нь сургалтын хөтөлбөр болон хичээлийн зохион байгуулалттай холбоотойгоор одоогийн байдалд хэрэгжих боломжгүй байна. Тухайлбал, танхимаас гадуурх хичээл нь ихээхэн цаг, зохион байгуулалтыг шаарддаг тул энэ талаар хөтөлбөр дээр тодорхой зааварчилга байхгүй, нөгөө талаас сургалтын менежерүүд зөвшөөрдөггүй зэрэг шалтгаануудыг дурджээ.

Судалгааны тайлан, дүгнэлтээс үзэхэд, иж бүрэн, нямбай боловсруулагдсан сурган хүмүүжүүлэх ухаан, заах арга барилыг тусгасан багшийн гарын авлага, материал дутмаг байгааг харуулж байна. Тухайлбал, бага ангийн багш нарт шинээр гарсан сургалтын хөтөлбөр, сурах бичгийг ашиглан хичээл заахад дэмжлэг хэрэгтэй байна. Тэд маш тодорхой дэмжлэгийг тухайлбал, сурах бичгийн зохиогчдоос болон мэргэжил арга зүйн багууллагаас тодорхой сургалт авахыг хүсэж байна. Харин дунд, ахлах ангийн хувьд тодорхой, нэгдсэн сургалтын хөтөлбөр, хэрэглэгдэхүүн байхгүй байгаа нь асуудал болж байна. Тэд юу хэрэгтэй гэж үзсэн, тэдэнд ямар материал олдсон зэргийг л үндэслэн хичээлийн агуулгыг боловсруулж байна гэж үзэхэд хилсдэхгүй байна.

#### **Багш нарын мэргэжлийн бэлтгэл:**

Иргэний боловсролын сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн нэг чухал асуудал бол багш нарын мэргэжлийн бэлтгэл, тэдгээрийг давтан сургах асуудал юм. Өөрөөр хэлбэл, тухайн хичээлийг сургалтын хөтөлбөрт тусгаад, сурах бичгийг нь хэвлүүлэн тарааснаар шийдэгддэг асуудал биш, харин хичээл заах багш маань энэ чиглэлээрээ хэр бэлтгэгдсэн бэ гэдэгт гол асуудал байгааг судалгаанд оролцогчид чухалчилж байна. Өөрөөр хэлбэл, тухайн хичээлийг зааж буй багш, сургалтын менежер, захирал зэрэг сурган хүмүүжүүлэгчид иргэний боловсрол эзэмшүүлэх мэдлэг, чадвар, үнэт зүйлсийг өөрсдөө эзэмшсэн байх нь нэн түрүүнд тавигдах шаардлага болжээ.

Судалгааны дүн бидэнд иргэний боловсролын хичээлийг зааж буй багш нарын мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагааны хоосон орон зайг улам бүр тод харууллаа. Иргэний боловсрол зааж буй багш нарын мэргэжлийг ганц нэг төрийн бус байгууллага, хувь хүн л төсөл, хөтөлбөрийн хүрээнд, ихээхэн хязгаарлагдмал байдалтайгаар дээшлүүлж байна гэж үзэж болохоор байна.

Багш нарын зүгээс өөрсдийн мэргэжлээ дээшлүүлэх чиглэлээр дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

- Иргэний боловсролын хичээлийн багш нарыг мэргэшүүлэх сургалтад хамруулах. Үүний тулд заавал нийгэм, түүхийн багш нарыг гэж явцуурах шаардлагагүй бөгөөд энэ хичээлийг заах, мэргэших сонирхолтой багш нарыг хамруулах
- Нийгмийн ухааны болон бага ангийн багш нарын хамтын ажиллагаан дээр тулгуурласан сургууль түшиглэсэн мэргэжил дээшлүүлэх ажлыг зохион байгуулах
- Орон нутагт болон үндэсний хэмжээний нэгдсэн сургалтыг зохион байгуулах зэрэг саналууд гаргасан байна.

Багш нарт зориулсан сургалт, семинарын хувьд:

- лекц унших биш, тодорхой сэдвийг заах арга зүйг турших, үзүүлэх
- танхимын бус хэлбэрээр хичээл зохион байгуулах арга зүйн талаар харилцан туршлага солилцох зэрэг олон хэлбэрүүдийг туршин хэрэгжүүлэх тухайд багш нарын ихээхэн хүлээлт байна.

Мөн сурах бичиг шинэчлэгдэх болгонд багш нар түүнтэй холбогдох сургалт, мэдээллийг авахыг хүсэж байна. Учир нь багш нарын хувьд хичээлдээ ашигладаг гол зэвсэг, туслагч нь сурах бичиг байх тул түүний талаарх мэдээлэл, арга, агуулгын өөрчлөлтийг мэдэх нь зайлшгүй шаардлагатай юм.

### **Хяналт, үнэлгээ:**

Иргэний боловсролын талаар олон улсын санаачлага, шинэчлэлтэд хийсэн дүн шинжилгээнээс үзэхэд уг боловсролын талаар олон янзын хандлага ажиглагдаж байна. Иймд энэ чиглэлийн олон улсын зохих туршлагаудыг судлан манайд тохиромжтой нөөц хэрэглэгдэхүүн, загваруудыг судлан, судалгаа, мэдээллийн нөөц бүрдүүлэх боломжийг хангах талаар ажиллахыг зөвлөж байна. Олон улсын туршлагаас харахад боловсролын салбарт иргэний боловсролыг нэвтрүүлэхэд одоо зааж буй сургалтын хөтөлбөрүүдэд уялдуулан нэгтгэх, багш, оюутнуудыг сургалтын гол асуудлуудтай танилцуулах нь илүү үр дүнтэй байна. Үүний тулд Иргэний боловсролыг эзэмшүүлэх сургалтанд нарийвчилсан хяналт, үнэлгээг тогтмол хийх шаардлагатай байна.

Нөгөө талаас ихэнх багш нар сурагчдаа үнэлж, мэдлэг, чадвараар нь жагсаах нэгдсэн үнэлгээтэй байдаг ба үүнийг ихэвчлэн “сурлагын амжилтын үнэлгээ” гэж нэрлэдэг. 1998 онд Блэк, Виллиам нарын хийсэн судалгаагаар сурлагын амжилтад үнэлгээ хийх нь сургалтын чанар, стандартыг сайжруулахад гол үүрэг гүйцэтгэдэг болохыг харуулжээ. Иймд Иргэний боловсролын сургалтын зорилго, зорилтууд, агуулгын хүрээ, түүний түвшинчлэл ба гүнзгийрэл, сурах бичиг, хичээлийн хөтөлбөр, сургалтын материалын хүрэлцээ хангамж, чанар, болон тухайн сургалтад эцэг эх, олон нийтийн оролцоог хангах болон багш бэлтгэх сургалтын чанарыг сайжруулах зэрэг асуудал тус бүрээр хяналт, үнэлгээний ажлыг хийж, түүний үр дүн, гарсан санал зөвлөмжийг холбогдох шийдвэр гаргагчдад хүргүүлж, эргэх холбоог тогтоон ажиллах нь эдгээр дурдсан асуудлыг шийдвэрлэхэд ихээхэн түлхэц болно.

### **Иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагаа -**

1990-ээд оноос хойш иргэний нийгмийн байгууллагууд иргэний боловсролын албан ба албан бус сургалтын чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд эдгээр байгууллагуудын олонх нь хүний эрхийг хамгаалах, ардчиллыг бэхжүүлэх, ардчилсан нийгэмд мэдлэгтэй, мэдээлэлтэй, хариуцлагатай, идэвхтэй иргэдийг төлөвшүүлэхэд хувь нэмрээ оруулах гэсэн зорилтыг өөрийн үйл ажиллагааны эрхэм зорилго болгон ажиллаж байна. Түүнчлэн ардчиллын, хүний эрхийн, сонгуулийн, эрх зүйн болон иргэний боловсрол, иргэдийн оролцоо зэрэг чиглэлээр, сургалт, семинар, хэлэлцүүлэг зохион байгуулах, бодлогын шинжилгээ хийх, хэвлэн нийтлэх зэрэг олон талын үйл ажиллагаа явуулж байгаа нь Монголчуудын иргэний

боловсролыг дээшлүүлэх, ардчилсан, хариуцлагатай иргэнийг төлөвшүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулж байгааг тэмдэглэх хэрэгтэй<sup>3</sup>.

Нөгөө талаас, Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа олон улсын байгууллагууд, тухайлбал, НҮБХХ, АНУ-ын Азийн сан, Конрад Аденаурын сан, АНУ-ын БНОУХ зэрэг байгууллагууд иргэний боловсролыг дэмжих, түгээн дэлгэрүүлэх чиглэлээр өргөн хүрээтэй үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр байгууллагууд юуны өмнө монголын төрийн бус байгууллагуудын иргэний боловсролын чиглэлээр хэрэгжүүлсэн хөтөлбөр, үйл ажиллагааг санхүүжүүлэх ажлыг хийдэг байна. Гэвч судлаачдын дүгнэж байгаагаар ТББ-уудын дийлэнх нь шинээр үүсэн байгуулагдсан буюу өсөлтийн үедээ явж байгаа тул боловсон хүчин, санхүүгийн чадавхи нь сул хэвээр байна. Иймд иргэний боловсролын чиглэлээр ТББ-уудаас хэрэгжүүлж буй арга хэмжээнүүд нь нэгдсэн хөтөлбөртэй болоогүй тул хүн амыг хамрах хүрээг өргөтгөх, үйл ажиллагааны үр өгөөжийг дээшлүүлэх, төрийн байгууллагууд, ТББ-ууд хамтарч ажиллах, хүчээ нэгтгэх зэрэг цаашдын олон сорилтууд хүлээж байна.

Иргэний боловсролын чиглэлээр ажиллаж буй ТББ-ууд нь Иргэний боловсрол хичээл нь хувь хүний чадавхийг дээшлүүлдэг, нийгэмд хэрхэн зохицож амьдрах тухай хүүхэд залуучуудад зааж өгдөг, зөв хүн байх, уламжлал, соёлоо мэддэг хүн болоход дэмжихүйц агуулгатай байхыг зөвлөж байна. Мөн судалгаанд оролцсон иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлүүд нь сургууль, иргэний нийгмийн хамтын ажиллагааны өргөн боломжийг ашиглахыг санал болгож байна. Тухайлбал, иргэний боловсрол хичээлийг хүүхдийн оролцоо, хэрэгцээ сонирхолд нийцсэн байдлаар танхимаас гадуурх сургалтын арга хэлбэрээр зохион байгуулахыг ихээхэн онцолсон байна. Мөн тэдний зүгээс сургууль түшиглэсэн үйл ажиллагаануудыг зохион байгуулдаг тул иргэний нийгмийн байгууллагуудын оролцоо, дэмжлэгт суурилсан сургалтын оновчтой хувилбарыг хэрэгжүүлэх тал дээр хамтран ажиллах боломжтой болохоо илэрхийлж байна.

ТББ-уудын иргэний боловсролын чиглэлээр оруулж буй томоохон хувь нэмэр нь багш нарыг чадавхижуулах, тэдний ур чадварыг нэмэгдүүлэх явдал юм. Аливаа сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд багш нар гол үүрэг гүйцэтгэдэг тул тэдний дэмжлэг, оролцоонд түшиглэн үйл ажиллагаагаа явуулдаг байна. Тиймээс иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран багш нарын мэргэжил дээшлүүлэх ажлыг зохион байгуулах, тогтвортой хэрэгжүүлэх боломж байгааг тэмдэглэж байна.

### **Санал зөвлөмж:**

Судалгааны ажлын гол зорилт нь ЕБС-ийн тогтолцоон дахь Иргэний боловсролын агуулга, арга зүйн талаарх санал байр суурийг нэгтгэх, дүн шинжилгээ хийсний үндсэн дээр Иргэний боловсролын сургалтын хөтөлбөр боловсруулах ажлын хэсэгт өгөх санал боловсруулахад оршиж байна. Иймд судлаачдын багийн зүгээс судалгааны дүн шинжилгээ, дүгнэлтэд үндэслэн дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

1. Иргэний боловсролын сургалтын хөтөлбөрт хувь хүн ба нийгмийн, иргэн ба төрийн, иргэн ба ардчилсан ёсны, мөн иргэний эрх ба үүргийн хоорондын харилцааг тусгахыг зөвлөмжилсөн ЮНЕСКО-ийн зөвлөмжид нийцсэн хөтөлбөрийн агуулга, үнэт зүйлсийн

<sup>3</sup> Иргэний сонгогчийн боловсрол судалгааны тайлан. УТБА. УБ., 2007

тогтолцоог агуулсан Иргэний боловсролын үзэл баримтлалыг боловсруулах ажлыг нэн түрүүнд гүйцэтгэх,

2. Иргэний боловсролын сургалтын хөтөлбөрийн агуулгыг нийгмийн, ёс суртахууны, соёлын, хүний эрх, эрх зүйн болон эдийн засгийн гэсэн 5 үндсэн ай (домайн)-н хүрээнд боловсруулж, боловсролын түвшинд бүрд тавигдах агуулгын өргөжилт, ойлголтын гүнзгийрэл, түвшний ялгаа тус бүрийг оновчтой гаргах, Хөтөлбөрийн агуулга буюу цөм ойлголтууд тус бүр харгалзах сургалтын арга зүй, үнэлгээний хувилбаруудыг боловсруулж, сургалтад нэвтрүүлэх, туршилтын үйл ажиллагаа зохион байгуулах
3. Ерөнхий боловсролын сургуулиудад иргэний боловсрол олгоход удирдлага болгон баримтлах стандарт, арга зүйн зөвлөмжийг нэн даруй боловсруулахыг зөвлөж байна. Үүнд тухайн боловсролын хэтийн зорилго, хөтөлбөрийн шинэчлэл, сурагчдын нас, ангийн түвшинд тохирсон сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах, зорилтот бүлгүүдийн мэргэжлийг дээшлүүлэх, үнэлгээ шинжилгээний тогтолцоог бий болгох зэргийг хамруулах ёстой. Ялангуяа тухайн боловсролыг олгох хэрэгцээ шаардлагыг бусад хичээлийн хөтөлбөрүүдтэй хэрхэн уялдуулан оруулах талаарх үндэслэлийг агуулсан товч арга зүйн үндэслэлийг боловсруулах хэрэгтэй байна. Арга зүйн үндэслэлийг холбогдох байгууллага, мэргэжилтнүүдтэй зөвлөлдөн, дараах бүтцээр боловсруулахыг санал болгож байна. Үүнд: а) Боловсролын хэрэгцээ, шаардлага, б) Сургалтын зорилго, зорилтууд, в) Суралцах агуулгын хүрээ, түүний түвшинчлэл ба гүнзгийрэл, г) Сурах бичиг, хичээлийн хөтөлбөр, мэргэжлийн сургалтын материалын хэрэглээ, боловсруулалт, д/ Эцэг эх, олон нийтийн оролцоог хангах, сургуулиас гадуур хичээлийг зохион байгуулах боломжит хувилбаруудыг боловсруулах зэрэг болно.
4. Иргэний боловсролыг албан боловсролын хөтөлбөр болон интеграцчилсан хичээлийн хөтөлбөрт оруулахад чиглэсэн багш, боловсролын судлаачдын мэргэжил дээшлүүлэх сургалтын тогтолцоо бий болгон хөгжүүлэх, мөн дээр дурдсан арга зүйн зөвлөмж, болон сургалтын хөтөлбөрийн арга зүйн хэсэгт танхимаас гадуурх хичээл, сургалтын загварчилсан удирдамжуудыг боловсруулан оруулж, хэрхэн зохион байгуулах талаар багш, сургалтын менежерүүдэд зориулсан сургалт семинарыг үе шаттай зохион байгуулж, түгээн дэлгэрүүлэх
5. Багш, сурган хүмүүжүүлэгчид суралцахуйн онол, эрхэд суурилсан сургалтын арга зүй, болон суралцах стратегиудийг өргөн хүрээнд ашиглах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, харилцан туршлага солилцох уулзалт, сургалтуудыг зохион байгуулах, сурагчдынхаа дунд хэлэлцүүлэг зохион байгуулах, асуудлын шийдлийг тодорхойлох, хамтран суралцах, дүрд тоглох, бие даан суралцах дадлага ажил зэргээр бүтээлч, шинэлэг арга зүйн хувилбаруудыг сургалтдаа нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх
6. Иргэний боловсролын чиглэлээр ажилладаг сургагч багш нар, хүүхэд залуучуудад зориулсан нэгдсэн вэб хуудас нээх, оролцогч бүрт тохирсон материал, зөвлөгөө, холбоосуудыг оруулж өгөх шаардлагатай байна. Энэхүү вэб хуудас нь хүүхэд, залуус, багш, оюутнуудад дэмжлэг үзүүлэх виртуал орчин болж, улмаар бусад улс, орон нутгийн суралцагчидтай хамтран Иргэний оролцооны төслүүдэд хамрагдаж, хамтран ажиллах боломжийг олгох

7. Иргэний боловсролын сургалтын зорилго, агуулгын хүрээ, түүний түвшинчлэл ба гүнзгийрэл, сурах бичиг, хичээлийн хөтөлбөр, сургалтын материалын хүрэлцээ хангамж, чанар, болон тухайн сургалтад эцэг эх, олон нийтийн оролцоог хангах зэрэг асуудлаар шинжилгээ, үнэлгээний ажил зохион байгуулж, түүний үр дүн, санал зөвлөмжийг холбогдох талуудад хүргүүлж, эргэх холбоог тогтоон ажиллах
8. Иргэний боловсролыг албан боловсролын хүрээнд болон танхимын бус арга хэлбэрээр зэрэгцүүлэн зохион байгуулах “Иргэний сургууль”-ийн загварыг боловсруулж, тухайн хөтөлбөрийг турших сургагч багшийн багийг бэлтгэх, чадваржуулах
9. Иргэний боловсролын үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн институтуудыг чадавхижуулах, төрийн зарим чиг үүргийг гэрээний дагуу хэрэгжүүлэх ажлыг иргэний боловсролыг түгээн дэлгэрүүлэхэд нэвтрүүлэх, бусад хэлбэрийн дэмжлэг үзүүлэх эрх зүйн орчин бүрдүүлэх

## Ашигласан материал

### Монгол улсын хуулиуд, үзэл баримтлал, хөтөлбөрүүд.

- 1 Монгол улсын үндсэн хууль УБ., 1992
- 2 Монгол улсын Боловсролын тухай хууль. УБ., 2002
- 3 Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого УБ., 2002
- 4 Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр. УБ., 2003 он,
- 5 Бага дунд боловсролын киррикулим болон стандарт шинэчлэн хөгжүүлэх үзэл баримтлал. БСШУ-ны сайдын 2002 оны 202-р тушаалын хавсралт.

### Сонин, сэтгүүл, хурлын материал, илтгэл, судалгааны тайлан

- 6 Туяа У., Алтангэрэл Ч., “Иргэний боловсрол. Ойлголт, хандлага”. “Боловсрол судлал”. №2. 2007
- 7 Туяа У., Иргэний боловсрол. “Шинэ толь” сэтгүүл. №59. 2007 он.
- 8 “Монголын боловсролын салбарын нөхцөл байдлын судалгаа”, 2005 он,
- 9 Иргэний сонгогчийн боловсрол судалгааны тайлан. УТБА. УБ., 2007
- 10 Фелиса Тиббетс “Латин Америк дахь иргэний боловсрол: Ирээдүйд бэлтгэх нь” Судалгааны тайлан 1999

### Электрон мэдээллийн эх сурвалжууд

- 11 [www.open-government.mn](http://www.open-government.mn)
- 12 <http://portal.unesco.org/education/en> Civics education for the twenty-first century
- 13 [www.ug.ru/civicnet](http://www.ug.ru/civicnet)

### Судалгааны мэдээлэл, эх сурвалжууд

- 14 Ярилцлагын мэдээлэл, тайлан
- 15 Асуулгын судалгааны мэдээлэл, тайлан